

**“ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

*/Хот байгуулалт, төлөвлөлт, Дэд бүтэц, Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх,
Ажлын байр нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих, Үйлдвэржилтийг дэмжих, Шилжилт
хөдөлгөөнийг сааруулах зорилтын хүрээнд/*

№	Хөтөлбөр, төслийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар /Жич: уялдаа холбоо бүхий дэд төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана./	Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улс, орон нутгийн төсөв /зээл, буцалтгүй тусламж/
3	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/	Барилга, хот байгуулалтын яам Хөтөлбөр 2010-2016 онд 2 үе шаттай хэрэгжинэ. I үе шат: 2010-2012 он II үе шат: 2013-2016 он
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>4.4.1. Хот байгуулалт, төлөвлөлтийн зорилтын хүрээнд</p> <p>4.4.2. Дэд бүтцийн зорилтын хүрээнд</p> <p>4.4.3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд</p> <p>4.4.4. Ажлын байр нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих зорилтын хүрээнд</p> <p>4.4.7. Үйлдвэржилтийг дэмжих зорилтын хүрээнд</p> <p>4.4.8. Шилжилт хөдөлгөөнийг сааруулах зорилтын хүрээнд</p>
5	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичнэ.
4.4.1.Хот байгуулалт, төлөвлөлт зорилтын хүрээнд		
1	4.4.1.1. Хотууд болон бүсийн тулгуур төвүүдийг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж мөрдүүлэх, 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг газар зохион байгуулалт, барилгажилт, газар хөдлөлийн мужлал, нийтийн тээврийн сүлжээний оновчтой шийдлийг харгалзан боловсруулах	<p>УИХ-ын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг баталсан. Тус тогтоолын дагуу НЗДТГ-аас “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, нийслэлийн холбогдох шатны хурлуудаар хэлэлцүүлж БХБЯ-нд ирүүлсний дагуу 2015.09.30-ны өдрийн 1/2876 тоот албан бичгээр яамдаас саналыг авч тусган БХБ-ын Сайдын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлэн болоод байна.</p> <p>Улсын төсвийн хөрөнгөөр Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Дорноговь аймгийн төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.Үүнд:</p> <p>Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2014.12.03-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, тус хурлын 50 дугаар тогтоолоор баталсан болно. 2015.09.18-ны өдөр “Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах гэрээт ажлын “Эцсийн шатны тайлан” ирүүлсэнийг хянан үзэж албажуулсан.</p> <p>Говьсүмбэр аймгийн төвийн хөгжлийн ерөнхий</p>

	<p>төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 2013 оны 12 дугаар сарын 10-ны 325 тоот гэрээг “Форум Арт” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу орон нутаг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зүй, аргачлалын талаар сургалт зохион байгуулах талаар 2015.02.18-ны өдрийн 7/524 тоот албан бичгийг “Форум Арт” ХХК-д тус тус хүргүүлэв.</p> <p>- Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгэгч “Аркетайп-Монголиа” ХХК боловсруулан, тус ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүдийг БХБ-ын сайдын 2014 оны 02 тоот тушаалаар томилон, Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>-Ховд аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө-ний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүдийг томилон, зураг төслийн баримт бичигт 2015.03.31-ний өдрийн 273/2015 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан. Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2014 оны 6/07 дугаар тогтоолоор Ховд аймгийн Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн дэмжсэн болно.</p> <p>-Төв аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-ний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүдийг томилон, зураг төслийн баримт бичигт 2015.02.02-ний өдрийн 96/2015 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулаад байна. Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн хурлын 2014 оны 33 тоот тогтоолоор Төв аймгийн Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус дэмжсэн болно.</p> <p>- Төв, Ховд аймгийн төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Хот байгуулалтын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д “бүсийн хөгжлийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар батлах”-аар заасны дагуу 2015.12.03-ны өдрийн ШУТНХБЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>- Говь-Алтай, Дундговь аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гэрээг 2014 оны 08 дугаар сарын 18-ны 73 тоот, 2014 оны 08 дугаар сарын 19-ний 74 тоот гэрээг “Эн Эй Пи” ХХК-тай, Дорнод аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах гэрээг 2014 оны 09 дүгээр сарын 15-ны 82 тоот гэрээг “Кёнжин архитектор номад” ХХК-тай, Сүхбаатар аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 2014 оны 09 дүгээр сарын 15-ны 83 тоот гэрээг “Түмэд групп” ХХК-тай, Увс аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 2014 оны 09 дүгээр сарын 15-ны 81 тоот гэрээг “Некстстеп инженеринг” ХХК-тай тус тус байгуулан ажиллаж байна.</p> <p>- “Эн Эй Пи” ХХК-ийн боловсруулсан Говь-Алтай аймгийн төв Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн баримт бичигт</p>
--	---

	<p>экспертиз хийх орон тооны бус экспертүүдийг БХБ-ын сайдын 2015.03.11-ний өдрийн 54 дүгээр тушаалаар томилж, 2015.08.28-ны өдрийн 1026/2015 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2014.03.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 11 дүгээр тогтоолоор баталсан болно.</p> <p>- Мөн “Эн Эй Пи” ХХК-ийн боловсруулсан Дундговь аймгийн төв Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүдийг БХБ-ын сайдын 2015.07.08-ны өдрийн 150 дугаар тушаалаар томилж, 2015.10.27-ны өдрийн 1118/2015 тоот экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан.</p> <p>Архангай аймаг: 2015 онд орон нутгийн хөгжлийн сангаас 300.0 сая төгрөгөөр Цэнхэр, Тариат, Цахир, Цэцэрлэг, Эрдэнэмандал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Эрдэнэбулган сумын Нисэх хороололд 58 га газарт шинээр баригдах барилгуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК-аар 115 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн.</p> <p>Баянхонгор аймаг: Аймгийн 2013-2033 оны ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, тодотгол хийхээр Солонгосын “Сүсон инженеринг” ХХК-тай 2013 онд орон нутгийн төсвөөс 196,9 сая төгрөг, 2014 онд улсын төсвөөс 741,0 сая төгрөг нийт 937,94 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд Баянхонгор хотын 2000 га талбайд төлөвлөлт хийгдэж байна. Олон нийтийн хэлэлцүүлэг багийн иргэд, холбогдох мэргэжилтэнүүдийг оролцуулан 6-8 удаа санал авч хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>Булган аймаг: Булган аймгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 15 га газарт боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын “Нарт дизайн” ХХК шалгарч 53 сая төгрөгөөр эдэлбэр газартай амины орон сууцны хороолол, нийтийн орон сууцны хороолол, үйлчилгээ, амралтын бүсийн хэсэгчилсэн төлөвлөлтийг боловсруулсан.</p> <p>2013-2016 онд сумдын хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг доорх сумд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. Үүнд: Бүрэгхангай сум “Инженер геологи” ХХК-тай 36.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар улсын экспертезээр хянагдаж байна. Гурванбулаг, Хишиг-Өндөр сумдыг “Инженер Геологи” ХХК /34.0, 35,0 / нийт 69,0 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд гэрээний дагуу 2014 оны 4 дүгээр сард өгөх байсан боловч экспертизийн шатандаа хяналт үргэлжилж байна. Сэлэнгэ сумын ерөнхий төлөвлөгөөг “Тэгш Хэм” ХХК 60.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Хутаг-Өндөр сумын Хантай багийн төвийн ерөнхий төлөвлөгөөг экспертизээр хянуулж байна. Тэшиг, Хангал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Эрхэт Констракшн” ХХК гүйцэтгэн 2015 оны 10-р сард сумын ИТХ-аар хэлэлцүүлэн хүлээлгэн өгсөн.</p>
--	---

	<p>Говь-Алтай аймаг: Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015-2016 онуудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөл боловсруулах ажлын багц-1 буюу Говь-Алтай аймгийн төв Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг барилгын зураг төслийн “Эн Эй Пй” ХХК БХБЯ-ны 2014 оны 8-р сарын 14-ны өдрийн 73 тоот гэрээ, ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаварт үндэслэн боловсруулж дууссан бөгөөд баримт бичиг, зураг төсөлд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГазраар магадлал хийлгэн баталгаажуулсан. Ерөнхий төлөвлөгөөний ажлыг 2015 оны 10-р сарын 7-ны өдөр аймгийн ГХБХБГ, Есөнбулаг сумын ЗДТГазар хүлээн авсан. 2014-2015 онд хот төлөвлөлтийн “Эн Эй Пи” ХХК-д боловсруулсан Говь-Алтай аймгийн төв Алтай хотыг 2015-2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авч, Алтай, Баян-Уул, Бугат сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хот төлөвлөлтийн “Эрхэт констракшн” ХХК-р гүйцэтгүүж байна.</p> <p>Говьсүмбэр аймаг: Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгөөр БХБЯ-ны захиалгаар тендер зарлаж гүйцэтгэгчээр “Форум арт” ХХК шалгарч гэрээ байгуулан, гүйцэтгүүлж, 2014 онд аймгийн ИТХуралд хүлээлгэн өгөөд байна. Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө 158 сая төгрөгөөр “ХБХДТ” ХХК боловсруулж хүлээлгэн өгөх шатандаа байна. Аймгийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумд нийт 84 иргэнд шинээр газар олгож, дуудлага худалдаагаар 2 албан байгууллагад зам дагуу үйлчилгээний газар, Баянтал сумд 68 иргэнд, Шивээговь сумд 240 иргэнд газар олгож дуудлага худалдаагаар 5 аж ахуйн нэгжид үйлчилгээний газар тус тус олгосон. Мөн Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа соёл амралтын хүрээлэнгийн ажил бүрэн дууссан байна. Мөн эрчимжсэн мал аж ахуйн бүсийг шинээр төлөвлөн бүсчилсэн ерөнхий төлөвлөгөө хийж худаг гарган цахилгааны шугам татан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд газар олгож эхлээд байна.</p> <p>Дархан-Уул: Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, тодотгохоор “Арт констракшн”ХХК-тай гэрээ байгуулж 4000га-д төлөвлөлт хийлгэхээр ажлын даалгавар боловсруулан өгч зураг төслийн ажлыг эхлүүлэн ажлын явцын эхний тайланг гаргуулан аваад байсан боловч гэрээ цуцлагдаж ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил зогссон. /800 сая төг/ Дархан хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөг шинэчлэх асуудлын хүрээнд Дархан сумын 3,11,12,13,24,25,29,31–р хорооллын 196 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний барилгажилт, замын сүлжээний төслийг “Монмос”ХХК-аар гүйцэтгүүлэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээр батлуулсан. 2015 онд Дархан сумын Малчин баг, Хөтөл хорооллын 154 га талбайн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 20 сая төгрөгөөр “Өргөө дизайн” ХХК-</p>
--	---

	<p>аар гүйцэтгүүлж, батлуулсан. Шарын гол сумын төвийн 750 га талбайн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг "Нарт дизайн" ХХК-аар 79 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн. Орхон сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Дархан-Уул аймгийн "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г "Геоботаник" ХХК-тай 58 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд төлөвлөлт боловсруулалтын ажил дуусаж батлагдах шатандаа явагдаж байна.</p> <p>Дорнод аймаг: Аймаг бүрт "1000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 48 га газарт орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Франц улсын хөрөнгө оруулалттай "Архетайп монголиа" ХХК, монголын "Нарт дизайн" ХХК-тай хамтран гүйцэтгэж захиалагч байгууллага болох БХБЯ, Дорнод аймгийн ГХБХБГазарт хүлээлгэж өгөөд байна. Уг зураг төсөлд 1800 айлын нийтийн болон амины орон сууц, сургууль, цэцэрлэг, урлаг соёлын төв, спорт амралтын төв, гал унтраах анги байхаар иж бүрнээр нь төлөвлөсөн байна. Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголын зураг төслийн ажлыг БНСУ-ын хөрөнгө оруулалттай "Кёнжин архитектур номад", "Говь тревэл" ХХК-ийн түншлэл 702.0 сая төгрөгний төсөвт өртөгтэйгөөр гүйцэтгэж байна.</p> <p>Дорноговь аймаг: Дорноговь аймаг нь 14 сумтай бөгөөд Мандах сумаас бусад сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийн асуудлыг аймаг, сумын удирдлагуудад танилцуулан ИТХ-аар батлуулж, шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж дуусгаад байна. 2010 онд Замын-Үүд сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010.12.26-ны өдрийн 6/11 тогтоолоор батлуулсан. 2011 оноос хойш Сайншанд хотын ерөнхий төлөвлөгөөг БХБЯамны захиалгаар АХБ-ны санхүүжилтээр боловсруулан гүйцэтгүүлж, 2013 оны АИТХ-аар батлуулан 2015 оны 09 дүгээр сарын 15-нд гүйцэтгэлийн ажлыг дуусган албан ёсоор хүлээн аваад байна. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015.07.01-ний 30 тоот тогтоолоор "Инженер Геодизи" ХХК-иар гүйцэтгүүлсэн Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Сайхандулаан, Эрдэнэ сумдын 2015-2025 он хүртэлх хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус батлуулаад байна. Мөн 2015 оны 10 дугаар сард Хамарын хийдийн аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөг гүйцэтгүүлж дуусган улсын экспертизээр хянуулж байна. Сумдын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах орон нутгийн санал, дүгнэлтийг боловсруулж тусгах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг аймгийн Ерөнхий архитектор удирдан зохион байгуулж буй бөгөөд сумдын Засаг дарга нарт болон холбогдох газруудад 2015 оны 1/495 албан бичгээр ЕТ-г мөрдөж ажиллах зөвлөмж чиглэлийг хүргүүлээд</p>
--	--

	<p>байна. “Шинэ Сайншанд” шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг мөн АХБ-ны санхүүжилтээр “АЕСОМ”, “Мон-Инжэкон”ХХК, “Мон-Энержи консалт”ХХК, “Эм Си Ди Эс”ХХК-ууд боловсруулж дуусган 2015.09.15-нд хүлээлгэн өгсөн бөгөөд 11.5 га газрыг хамрах бөгөөд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу АХБ-ны хөрөнгөөр 8.4 Мв дулааны станцыг баригдаж 2015 оны 05-р сард ашиглалтанд оруулаад байна. Дээрх ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн төсвөөс 541 сая төг, улсын төсвөөс 330 сая, АХБ-ны санхүүжилтээр 148 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Дорноговь аймгийн хэмжээнд 2010 оноос хойш аймгийн төв болон сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон ХЕТ боловсруулахад нийт 1 тэрбум гаруй төгрөгийг шийдвэрлүүлсэн байна.</p> <p>Орхон аймаг: Эрдэнэт хотын суурьшлын бүсийг оновчтой төлөвлөх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон тодотгол хийж, шинэ суурьшлын болон хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тодотгон газар ашиглалтыг сайжруулан зөв зохистой хуваарилах зорилт тавин ажиллаж тайлант жилийн хугацаанд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх саналыг боловсруулан, 3-н байршил /Шар чулуут уулын энгэрт энгэрт 120 га, Төмөр замын өртөө орчимд 170га, Эрдэнэт цэнгэлдэх хүрээлэн биеийн тамир спортын бүсийн 235га/-д хот төлөвлөлтийн баримт бичиг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг боловсруулан Аймгийн Засаг даргаар баталгаажуулж, орон сууцны 7 дугаар хороололд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг эрх бүхий байгууллагад захиалан хийлгэн АИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулсан.</p> <p>Хот байгуулалтын дахин төлөвлөлт хийгдэх шаардлагатай 8, 9, 12 дугаар орон сууцны хороолол баригдахаар төлөвлөгдсөн гэр хорооллын 80 орчим га, хотын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардлагатай 517га газруудад хот байгуулалтын суурь судалгааны материал болох геодезийн агууламж бүхий байр зүйн дэвсгэр зураглалыг хийлгэн хүлээн авсан.</p> <p>Орхон Булган аймгийн дундын бүс байгуулах санаачилгыг гарган хил залгаа Булган аймгийн Орхон, Сэлэнгэ, Хангал сумдын нутаг дэвсгэрт 4 байршилд нийт 800га газарт суурь судалгааны байр зүйн зураглалыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэн хүлээн авсан.</p> <p>2015 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт 125 барилга, байгууламж, гадна шугам сүлжээ, авто замын гүйцэтгэлийн зургийг хүлээн авсан байна. Үүнд:</p> <p>Цахилгаан хангамж, гудамжны гэрэлтүүлэг 13 ширхэг Инженерийн барилга, байгууламж, шугам сүлжээ 31 ширхэг Шинээр баригдсан үйлчилгээний барилга 5 ширхэг Орон сууцны барилга 5 ширхэг Сургууль, цэцэрлэг 2 ширхэг</p>
--	--

	<p>Авто замын гүйцэтгэл 10 ширхэг Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын гадна дулааны шугам сүлжээний 59 гүйцэтгэлийн зургийг шалгаж, мэдээллийн санд хүлээн авсан.</p> <p>Аймгийн сумдын 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хот байгуулалтын бодлого, чиглэлийн дагуу санал өгч инженерийн хангамжид холбогдох боломж бүхий газруудын судалгааг гарган байршил, хэмжээг тодорхойлон газар эзэмших эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын суурь даалгаврыг боловсруулсан.</p> <p>Өвөрхангай аймаг: Хот байгуулалтын чиглэлээр аймгийн хэмжээнд нийт 19 сумаас 12 суманд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн бөгөөд ерөнхий төлөвлөгөөний дагуу Арвайхээр, Хархорин сумдад хэсэгчилсэн төлөвлөгөө хийгдэж мөрдөн ажиллаж байна. Дээрх сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэнээр сумдын хөгжлийн бодлого боловсруулах боломж бүрдэж газар зохион байгуулалтын болон бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдлээ. Мөн Уянга сумын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх шаарлагатай байгаа. Баян-Өндөр, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Сант гэсэн 7 суманд хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэнээр аймгийн Хот багуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн ажил жигдрэх нөхцөл бүрдэнэ. Уг сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг хийлгэх шинэчлэгдсэн үнийн дүнг сум тус бүрээр нь гаргаж хүргүүлсэн ба төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн сангаас хасагдсан.</p> <p>Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2009 онд “Нарт дизайн” ХХК нь боловсруулж батлуулсанаар мөрдөж ажиллаж байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу “Орон сууцны хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 71 га-д БХБЯ-аас тендер зарлан Арвайхээр хотын шинэ төвд 3870 айлын орон сууцны хорооллын (5-9 давхар), ЕБСургууль 1, Цэцэрлэгийн барилга 4, Төрийн захиргааны байр, багийн төв, ерхийн эмнэлэг, кино театр, судалгаа шинжилгээ болон худалдаа, үйлчилгээний төвүүд бүхий хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан. Арвайхээр сумын шинэ төвд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 1180 айлын орон сууцны газрыг 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган олгосон. 150 хүүхдийн цэцэрлэг баригдан ашиглалтад орсон. 928 хүүхдийн сургууль баригдаж байна.</p> <p>Мөн бүсийн тулгуур төв болох Хархорин сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж эхэлсэн.</p> <p>Өмнөговь аймаг: Улсын хөрөнгө оруулалтаар Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулж 2015 онд хүлээлгэн өгсөнөөр хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Сүхбаатар аймаг: Халзан, Асгат сумдын ерөнхий төлөвлөгөөг шинээр, Баруун-Урт, Эрдэнэцагаан</p>
--	--

	<p>сумдын ерөнхий төлөвлөгөөг тодотгон шинэчлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. Баруун-Урт сумаас бусад 12 сумын ерөнхий төлөвлөгөөг 1978-1983 онуудад боловсруулсан бөгөөд Эрдэнэцагаан, Мөнххаан, Онгон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2008 онд тодотгох ажлыг “Нарт дизайн” ХХК-д боловсруулсан боловч одоогоор тухайн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мөрдөгдөхгүй, нийгэм эдийн засгийн хөгжлийн нийтлэг шаардлага, эрэлт хэрэгцээний дагуу зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлага тулгарсан. Иймд энэ талаар мэдээлэл судалгаа бэлтгэж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан 2013 оны орон нутгийн хөгжлийн сангийн 195.0 сая төгрөгийн хөрөнгөөр Асгат, Халзан, Баяндлэгэр, Мөнххаан, Уулбаян, Наран, Онгон, Түмэнцогт, Түвшинширээ, Сүхбаатар сумдын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, дахин төлөвлөлтийн зураг төслийг “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-д боловсруулсан.</p> <p>Сэлэнгэ аймаг: Цагааннуур, Хушаат, Жавхлант, Баруунбүрэн сумдын ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулсан. Мөн сумдын газар ашиглалт, ерөнхий төлөвлөгөөнд тулгамдаж буй асуудлын талаар санал танилцуулж хэрхэн шийдвэрлэх, иргэдийн оролцоотой газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалт семинар зохион байгуулсан. 17 сум 6 тосгонд “Хот байгуулалтын тухай хууль”, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө түүнийг хэрэгжүүлэх арга зам, талаар сум орон нутгийн иргэд, ИТХ, ЗДТГазар, холбогдох албан байгууллагуудад сургалт зохион байгуулсан. 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн аймгийн ИТХ-аар Сүхбаатар сумын 6-р баг 60 айлд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр 25 сая төгрөг тусгуулж батлуулсан.</p> <p>Төв аймаг: Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөөг олон улсын нисэх онгоцны буудал, Майдар сити зэрэг томоохон төслүүдтэй уялдуулах шинэчлэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр барилгын зураг төслийн “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК боловсруулан гүйцэтгэсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөөнд санал дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулан өргөтгөсөн хуралдааныг 3 удаа зохион байгуулж иргэдийн саналыг авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 09-р сарын 15- ны 59 тоот тогтоолоор Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжиж батлуулахаар Монгол Улсын Засгийн газарт уламжлуулсан. Аймгийн хэмжээнд бүх сумдыг хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй болгох зорилт тавин ажиллаж эхний ээлжинд хүн ам олноор суурьшсан томоохон сумдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг хийж байна. 2008-2014 онд Зуунмод, Баян, Эрдэнэ, Лүн, Баянчандмань, Эрдэнэсант, Жаргалант, Батсүмбэр, Борнуур, Бүрэн, Угтаал Алтанбулаг, Баянцогт сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг</p>
--	--

	<p>боловсруулаад байна. Одоо Сүмбэр, Цээл Баян, Баяндэлгэр, Заамар, Эрдэнэ Баян-Өнжүүл сумдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг барилгын зураг төслийн “Эрхэт констракшн” ХХК, “ХБХДТ”ХХК, “Арт констракшн”ХХК “Инженер геодези”ХХК, “ОБЭЭМ”ХХК-уудтай гэрээ байгуулан хийлгэж байна. Үүний үр дүнд 20 сум хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй болно.</p> <p>2015 онд Дэлгэрхаан, Баянжаргалан сумдын төвийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг “Эрхэт констракшн”ХХК боловсруулах гэрээ байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд 2016 оны эцэст 22 сум хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй болно.</p> <p>Увс аймаг: Увс аймаг нь 19 сумтай бөгөөд Улаангом, Тэс, Өндөрхангай сум хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийн асуудлыг аймаг, сумын удирдлагуудад танилцуулан ИТХ-аар батлуулж, шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж дуусгаад байна.</p> <p>2014-2030 онд Улаангом сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан.</p> <p>2016 оны 1-р улиралаар Улаангом хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлыг дуусган албан ёсоор хүлээн авахаар ажилласан. 2 сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах орон нутгийн санал, дүгнэлтийг боловсруулж тусгах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг аймгийн Ерөнхий архитектор удирдан зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд сумдын Засаг дарга нарт болон холбогдох газруудад ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг мөрдөж ажиллах зөвлөмж чиглэлийг хүргүүлсэн. Увс аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг “Некстстеп инженеринг” ХХК гүйцэтгэж байгаа ба суурин судалгааны материалаар бүрэн хангаж ажилласан. 2020-2030 онд хөгжүүлэхээр төлөвлөж буй аймгийн төвийн 2407га талбай, үйлдвэрийн районы 390 га талбай нийтдээ 2797 га талбайд инженер геологийн судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Нийтдээ 122 цооног 6-10,5м гүнтэй өрөмдөж инженер геологийн зураглалын ажил бэлэн болоод байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлыг үндэсний хорооны хэлэлцүүлэгт оруулан ярилцан ажиллаж ажлын явц 90%-тай явагдаж байна. 2016 оны 1-р улиралын байдлаар зураг төслийг бүрэн хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Увс аймгийн Тэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын хүрээнд 2015 онд "Нарт дизайн"ХХК-аар зураг төслийн ажил хийлгэн зургийн ажил бүрэн дуусч экспертизээр хянуулан баталгаажуулж ерөнхий дүгнэлт гаргуулан хүлээлгэн өгсөн.</p> <p>Хөвсгөл аймаг: Аймгийн хэмжээнд бүх сумдыг ерөнхий төлөвлөгөөтэй болгохоор анхааран ажиллаж байна. Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, дуусгаад байна. Тариалан сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумынхаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийн хүрээнд 200.0</p>
--	---

		<p>сая төгрөгөөр Цэцэрлэг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан магадлал хийлгэн, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болсон.</p>
2	<p>4.4.1.2. Улсын, бүсийн, аймгийн, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг бусад холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, байгаль орчинд ээлтэй, үргүй зардлыг багасгасан, эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд чиглэсэн байдлаар боловсруулж мөрдүүлэх</p>	<p>Барилгын хөгжлийн төвөөс 2014.11.03-ны өдрийн 1494/2014 дугаар бүхий Магадлалын ерөнхий дүгнэлтийг яаманд ирүүлсэн.</p> <p>Уг дүгнэлтийг үндэслэн “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг боловсруулах ажлын хүрээнд гүйцэтгэсэн бичиг баримт, зураглалын материалыг ГХГЗЗГ-ын Мэдээллийн төвийн Зураг, төсөл, шинжлэх ухаан техник технологийн баримт хүлээн авах тухай 2015.06.08-ны өдрийн №2015/ГЗБ/29 дугаар актаар хүлээн авсан.</p> <p>“Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг цаашид газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан шинэ арга зүйгээр боловсруулахаар “Газар дэлхий” ХХК ба ГХГЗЗГ-ын хооронд 2014 оны №2014/116 дугаартай ажил гүйцэтгэх нэмэлт гэрээг байгуулсан, мөн түүнчлэн “Инжгеотех” ХХК ба ГХГЗЗГ-ын хооронд 2013 оны №2013/66, 2014 оны №2014/115 дугаартай газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний зураг, газрын төлөв байдал, чанарын бүсийг тогтоох ажлыг гүйцэтгэх тухай гэрээнүүдийг тус тус байгуулан ажиллаж байна.</p>
3	<p>4.4.1.4. Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх</p>	<p>СХД-ийн 30-р хорооны нутаг дэвсгэрт 81.6 га талбайд "Хилчин" хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр "Монгол дайван" ХХК шалгаран ажиллаж байна. Уг компани иргэдтэйгээ зөвшилцөн, иргэдийн оролцоотой боловсруулсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлага"- тай уялдуулан боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>БГД-ийн 16-р хорооны нутаг дэвсгэрт "Гандантэгчилэн хороолол"-ын дахин төлөвлөлтийн зураг төслийг "Гудамж төсөл"-төй хамтран газар шинэчлэн зохион байгуулах ажлыг хийж байна.</p> <p>“Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах болон барилга угсралтын ажил” /ГХДТ-2013/01/-ын хүрээнд тус яам Барилгын хөгжлийн төвтэй хамтран 2015.01.10, 2015.03.30-ны өдрүүдэд дээрх хорооллуудын ажлын явц, гүйцэтгэлтэй газар дээр нь очиж танилцсан. Гүйцэтгэгч “Монгол Дайвин” ХХК-ийн төлөөллийг байлцуулан уулзалт зохион байгуулж, “Ажил эрчимжүүлэх тухай” 3/1112 тоот албан бичгийг гүйцэтгэгч компанид хүргүүлсэн.</p> <p>- Гүйцэтгэгч “Монгол Дайвин” ХХК нь НЗД-ын олгогдсон А/180 дугаар батламжаар эрх олгогдсоны дагуу нийслэлийн төсвөөс нүүрс шингэрүүлэх станцыг барьж, уг төслийн дулааны эх үүсвэрийг шийдвэрлэхээр төлөвлөсөн боловч энэхүү ажил удаашралтай байгаагаас барилга, угсралтын ажил түр зогсоод байна. Энэхүү ажлын хүрээнд 2015.06.04-ны өдөр зохион байгуулсан Нийслэлийн ИХ-ын дарга Д.Баттулга хийн станцын оронд уурын зуух барьж дулааны эх үүсвэрийг шийдвэрлэх, зураг</p>

		<p>төслийг боловсруулан батлуулахаар шийдвэрлээд байна.</p> <p>2015.09.18-ны өдөр “Монгол Улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь үе шатны төслийн багтай уулзаж, Улаанбаатар хотын гэр хорооллын дэд бүтцийн хангамжийн байдал, Сонгинохайрхан дүүргийн 30 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Шинэ хороолол” гэр хорооллын дахин зохион байгуулах төслийн явцын талаар танилцуулж, санал солилцсон.</p> <p>- Уг төсөл арга хэмжээний гүйцэтгэл удаашралтай байгаатай холбогдуулан 2015.12.03-ны өдөр захиалагчийн хяналтыг гүйцэтгэгч Барилгын хөгжлийн төвийн Захиалагчийн албаныханд зураг төслийн экспертизийн нэгдсэн дүгнэлтийг гаргуулах, барилгын ажлын явцад Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулах үүрэг чиглэл өгсөн.</p> <p>- Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгээс ирүүлсэн 2015.11.10-ны өдрийн 4/10070 тоот албан бичгийн дагуу Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ Сонгинохайрхан дүүргийн 30 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Шинэ хороолол” гэр хорооллын дахин зохион байгуулах төслийн явцтай 2015.12.10-ны өдөр танилцаж, ажил сайжруулахад чиглэсэн тодорхой үүрэг чиглэл өгч ажилласан.</p>
4	4.4.1.5. Хот байгуулалт, төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, дүрэм, журам, норм, норматив, стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах	<p>Улаанбаатар хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөлтийн хүрээнд Хот байгуулалт, газрын харилцааны асуудлыг холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлж дараах эрх зүйн актуудыг боловсруулсан.</p> <p>-“Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж НИТХ-ын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 5/14 дүгээр тогтоолоор батлуулав.</p> <p>-“Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөх барилгажуулах журам”-ыг боловсруулж НИТХТ-ийн 2014 оны хурлын 90 дүгээр тогтоолоор батлуулав. Журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн дүүргүүдээс ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийн өмчлөгч, хамтран эзэмшигчийн мэдээлэл лавлагааг гаргуулан нэгдсэн бүртгэлд авсан. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах тухай захирамжийн төсөл боловсруулж нийслэлийн Засаг даргын 2014 оны А/977 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгажилтын төсөл боловсруулж, ажил гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан компаниудыг батламжлах, төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан компаниудад сууц өмчлөгч болон Нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ байгуулах эрхийг олгох тухай нийслэлийн Засаг даргын 2014 оны А/1008, А/1009, А/1010 дугаар захирамжийг тус тус батлуулав.</p>

		<p>-“Нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах журам”-ыг боловсруулж НИТХТ-ийн 2014 оны 166 дугаар тогтоолоор батлуулав.</p> <p>-“Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих журам”-ыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/799 дугаар захирамжаар батлуулав.</p> <p>-“Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах, хоёр болон гурван талт гэрээний шинэчилсэн загварыг НИТХТ-ийн 2014 оны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>-“Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хуулийг боловсруулж, 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 195 дугаар тушаалаар тус хуулийг дагалдах дүрэм, журмыг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай” хуулийг дагалдах “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам”, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар” зэрэг холбогдох дүрэм, журам, зааврын төслийг боловсруулж байна.</p> <p>-Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хот, тосгоны ногоон байгууламжийн тухай, Авто зогсоолын тухай, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж байна.</p> <p>- “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах аргачилсан заавар”-ын төслийг шинэчлэн боловсруулж байна.</p> <p>- Уг зааврын төсөлд редакци, шүүмж хийсний дагуу хот төлөвлөгч нарын дунд 2015.10-30-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгээс уг зааврын төсөлд мэргэжлийн зөвлөхүүдийн санал зөвлөмжийг тусган, шинээр боловсруулах “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-тэй уялдуулах нь зүйтэй гэж үзсэн тул техникийн даалгаварт нэмэлт өөрчлөлтийг оруулах, заавар, норм боловсруулах зөвлөхийн багт зөвлөхүүдийг нэмж томилохтой холбогдуулан гарах зардлыг Барилгын норм, нормативын сангийн 2016 оны төлөвлөгөөнд тусгуулж батлуулахаар шийдвэрлэсэн болно.</p> <p>- Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт” (БНБД 30-01-04/14)-ийн норм ба дүрмийн төсөлд редакци, шүүмж хийгдэж, 2013.12.11-ний өдөр БХБЯ-ны дэргэдэх ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн.</p>
5	4.4.1.6. Хот байгуулалт, төлөвлөлтийг зохион байгуулахдаа инженерийн барилга байгууламж, нийтийн тээвэр, агаарын тээвэр, нийтийн	“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-т хот байгуулалт, төлөвлөлтийг зохион байгуулахдаа инженерийн барилга байгууламж, нийтийн тээвэр,

	аж ахуй, орон сууц, гэр хороолол, нийгмийн дэд бүтэц, газар ашиглалт зэргийг харгалзан олон улсын жишигт нийцүүлэн төлөвлөх	агаарын тээвэр, нийтийн аж ахуй, орон сууц, гэр хороолол, нийгмийн дэд бүтэц, газар ашиглалт зэргийг харгалзан төлөвлөхөөр тусгасан бөгөөд Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж байна.
6	4.4.1.7. Уул уурхай, үйлдвэрийг түшиглэн шинээр хот, суурин газруудыг төлөвлөн барьж байгуулах	<p>- 2015.03.13, 2015.03.25, 2015.04.14, 2015.04.20, 2015.04.23-ны өдрүүдэд гүйцэтгэгч “Арт констракшн” ХХК, тус яамны ХБГХБГ, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар хамтран Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зургийн даалгавар батлуулах, ажлын явц, төлөвлөлтийн шийдлийн талаар санал солилцож, уулзалт зохион байгуулсан. Үүний дагуу 2015.04.27-ны өдөр Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зургийн даалгаврын төслийг батлуулахаар Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газарт хүргүүлэн, 2015.05.22-ны өдрийн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, тосгоны /Багануур хот/ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” 07 дугаар зургийн даалгаврыг БХБ-ын сайдаар батлуулсан. Батлагдсан зургийн даалгаврыг 2015.05.29-ний өдрийн 3/1767 тоот албан бичгээр гүйцэтгэгч “Арт констракшн” ХХК-д хүргүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 388 дугаар тогтоолоор үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, тосгоны /Багануур/ хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах” ажлын эцсийн шатны тайланг хянан үзэж, баталгаажуулсан. Мөн Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүдийг БХБ-ын сайдын 2015 оны 241 дүгээр тушаалаар томилж, экспертиз хийгдэж байна.</p>
4.4.2. Дэд бүтцийн зорилтын хүрээнд		
7	4.4.2.1. шинээр болон шинэчлэн баригдах суурин газар, орон сууцны цогцолбор хорооллыг байгаль орчинд ээлтэй, бие даасан дулаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийн хамтаар бүтээн байгуулах	<p>Орон сууцны хотхон хорооллыг байгаль орчинд ээлтэй, бие даасан инженерийн дэд бүтцийн хамт бүтээн байгуулах ажлын хүрээнд 2015 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <p>1. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Замын-Үүд сум болон Эдийн засгийн чөлөөт бүсэд 4 багц арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: Ус хангамж, бохир ус ариутгах татуургын багц ажлын хүрээнд хоногт 3250 м³ ундны усыг цэвэршүүлэх байгууламжийн барилгыг барьж, тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, ус нөөцлөх 4x500 м³ усан сан, усны эх үүсвэрийн гүний 3 худгийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах 24,5 км шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдсэн. Хоногт 3640 м³ бохир усыг цэвэрлэх байгууламжийг лабораторийн барилгын хамт барьсан. Чөлөөт бүсэд бохир усны насосны станцын 1 барилга, бохир усны 9,1 км, цэвэрлэх байгууламжийн цэвэршүүл-сэн ус (саарал ус)-ыг дахин ашиглах 8,0 км шугам сүлжээний барилга угсралтын ажлууд хийгдсэн. Төсөл 2016 онд үргэлжлэн хэрэгжинэ.</p>

	<p>2. АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Өмнөговь болон Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204 МОН төсөл”-ийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 2х100м³ багтаамжтай усан сан, цэвэр усны 5,9 км шугам сүлжээ, 2,8 км бохир усны хоолой, гэр хороололд ус түгээх 3 байрыг барьж, 2015 онд ашиглалтад оруулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Мон инж бар” ХХК ажилласан. Ханбогд сумын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээг шинээр барих ажлын гүйцэтгэгчээр “Сан” ХХК шалгаран, ажиллаж байна.</p> <p>Дорноговь аймгийн Сайншанд суманд 8,4 мВт дулааны зуух, Замын-Үүд суманд цэвэр усны 13,4 км, бохир усны 7,87 км шугам хоолой, бохир усны насосны станц 2, ус түгээх 3 байр, дулааны шугам сүлжээ, ус дулаан дамжуулах 3 төв, дизель цахилгаан үүсгүүрийн 3 барилгыг барьж ашиглалтад оруулсан.</p> <p>3. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Хот байгуулалтын салбарын МОН 2301 төсөл”-ийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод усны эх үүсвэрийн гүний 3 худгийг шинээр, цэвэр ус дамжуулах 15 км хос шугам сүлжээ, 2-р өргөлтийн насос станц, 2х100 м³, 1х1000 м³ багтаамжтай усан сан-3ш, гэр хороололд цэвэр усны 9,9 км шугам сүлжээ, ус түгээх 17 байрыг тус тус шинээр барьж цэвэр усны төвлөрсөн сүлжээнд холбон ашиглалтад оруулсан.</p> <p><u>Орон нутагт:</u> Ховд аймгийн Жаргалант суманд хоногт 4200 м³ бохир усыг цэвэршүүлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг “Хөгжлийн банк”-ны санхүүжилтээр “Ховдын тулга” ХХК нь гүйцэтгэж байна.</p> <p><u>Улаанбаатар хотод:</u> Чингис бондын хөрөнгөөр:</p> <ul style="list-style-type: none"> - Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын цахилгааны ХБ 4ш, 9ш хаалттай дэд өртөө барьж байгуулах, өндөр хүчдэлийн 5900м кабель шугам, Дулааны эх үүсвэр -2 ш, дулааны ф80/300мм-ийн 2010 метр шугам, Усан хангамж ф500мм 1800 метр, ф80/300мм-ийн 3080 метр, ариутгах татуургын ф300 мм 1050 метр, ф400/200мм-ийн 1310 метр шугамын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70%-тай байна. - ЧД-ийн 13,15-р хороо, Цахилгааны хаалттай дэд өртөө 2х630КВА-1ш, 2х800КВА - 3ш, 3х185-ийн 1980 у/м кабель шугам, Дулаан хангамжийн эх үүсвэр уурын зуухны барилга -2ш, хатуу түлшний халаалтын тогоо -6ш, хэрэгцээний халуун усны ялтсан дулаан солилцуур-2 ком, Дулааны шугам сүлжээний Ф80/200 мм-ийн голчтой шугам 738 метр, Ф50/150 мм-ийн голчтой шугам 2410 метр, Цэвэр усны Ф32/150 мм-ийн 1400 метр шугам, Бохир усны Ф150/200мм-ийн 800 метр шугамын угсралтын ажил 70%-тай явагдаж байна. - Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын Цахилгааны хаалттай дэд өртөө /ХТП/-г 20 комплект, 10 кВ-н 28 км кабель шугам тавих, 10 кВ-н ХБ 2 ком, 4ш ус дулаан дамжуулах төв, цэвэр усны ф100-300м-ийн
--	--

	<p>3216 метр шугам, бохир усны ф150-300мм-ийн 1706 метр шугамын барилга угсралтын ажил 90%-тай явагдаж байна.</p> <p>- СХД-ийн 10-р хороо, 10 кв-ын ХТП-2 ш, цахилгааны 10кв-ын 1.5км кабель шугам, Дулааны ф65/200мм-ийн 924 метр шугам, Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлал, Усан хангамж ф32/150мм 871 метр шугам, ариутгах татуургын ф150/300мм-ийн голчтой 3100 метр шугамын барилга угсралтын ажил 50%-тай явагдаж байна.</p> <p>-“Дэд бүтэц” төслийн хүрээнд: Буянт-Ухаа орон сууцны хороолол/ОСХ/-ын 10 хэсгийн 10 ЦТП, гадна цахилгаан хангамжийн ажлаас Ус, дулаан дамжуулах төв /ЦТП-11/-ийг бүрэн хийж гүйцэтгэн 2015.04.23-нд улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан. Ирээдүй цогцолбор хорооллын бохир усны Ф150-500 мм-ийн 4,9 км гол шугамын болон бохир усны насосны станцын барилгын ажлыг бүрэн дуусгаж 2015.12.23-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Буянт-ухаагийн 20000 м³/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилгын ажил хийгдэж байна.</p> <p>Архангай аймаг: 2015 онд Архангай аймгийн Эрдэнэбулган суманд ус, дулаан, цахилгааны шугамыг 18.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн. 2014 онд Улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж байгаа “Булган хангай” хорооллын дулааны болон эрчим хүчний төв шугамын ажлыг “Соёндрийм” ХХК гүйцэтгэж 2015 оны 5-р сарын 18-нд ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Дулаан хангамжийн ажлыг зураг төсвийн дагуу 641 м дулаан, цэвэр, халуун усны эргэлтийн шугам, цахилгаан хангамжийн ажлаар ХТП-1, ХТП-2, РП-ны барилгын ажил, 10/0,4кВ-ын 630кВА –ын 2 ширхэг, 400кВА –ын 2 ширхэг трансформаторуудыг суурилуулсан. Шинээр баригдсан хувиарлах байгууламж /РП/-ээс ХТП-1, ХТП-2 хүртлэх кабелийн ажил мөн 110/35/10кВ-ын Цэцэрлэг дэд станцаас шинээр баригдсан хувиарлах байгууламж /РП/ хүртлэх ААБл(3*150) –ийн 3615 метр хос кабелийн ажил хийгдсэн.</p> <p>Эрдэнэбулган сумын цахилгааны 5 дэд станц шинэчлэх, 7,2 км цахилгааны шугамын ажлыг “Баянмогод”ХХК 540 сая төгрөгөөр мөн сумын 9-р цэцэрлэг, Ирээдүй сургуулийн гадна цэвэр 1.5 км, бохир усны 1.3 км шугамыг 510 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.</p> <p>Эрдэнэбулган сумын Эрчим хорооллын 76 айлын гадна цэвэр, бохир усны шугамын эхний ээлжийн ажлыг 398 сая төгрөгөөр, шинээр барих 5000м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн зураг төслийг 50 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн.</p> <p>Эрдэнэбулган суманд баригдах дулааны станцын зураг төслийг “Густо групп”-ээр 67 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн.</p> <p>Баян-өлгий аймаг: “Шинэ сум” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Цэнгэл сумын төвд дулааны 1760м урт өгөх, буцах 2 магистрал 3.6 мвт дулааны</p>
--	---

	<p>станц бүхий шугамыг (дулааны шугамд сургууль, цэцэрлэг, захиргааны байр г.м холбогдох байгуулагууд холбогдсон) ашиглалтанд оруулсан. Аймгийн төвд 2015 онд төвлөрсөн дулааны шугаманд нийт 7 айлыг холбож ф50 мм-ийн шугамын урт 120 метр, ф80 мм-ийн шугамын урт 20 метр, бүгд 140 метр өгөх, буцах шугамыг холбосон. Шинээр ашиглалтанд орсон 6 нийтийн орон сууцны барилгад дулаан алдагдлыг бууруулах технологийг ашигласан байна. Өлгий хотын цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх өргөтгөх, хүчин чадалыг нэмэгдүүлэх зураг төслийг боловсруулсан.</p> <p>Баянхонгор аймаг: Шинэ сумын төв төслийн хүрээнд Бууцагаан, Баянлиг сумдад цэвэрлэх байгууламж шинээр баригдаж ашиглалтад орсон. “Хонгор-1000” орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг “Сан” ХХК нийт 5.05 тэрбум төгрөгийн ажилд 1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж, 60 хувийн гүйцэтгэлтэй боловч үлдэгдэл хөрөнгө 4050.0 тэр бум төгрөгийн хөрөнгө шаардлагатай байгаагаас 2015 онд ажил зогссон. Баянхонгор сумын 9-р багт хийгдсэн бохирын шугамын ажлыг “Хөх бүрдний эх” ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэж өгсөн.</p> <p>Булган аймаг: Булган сумын 2-4-р цэцэрлэг хүртэлх бохир ус татан зайлуулах төв шугамыг орон нутгийн байгаль хамгаалах сангийн 187,0 сая төгрөгөөр Улаанбаатар хотын “Билгүүн Од Констаркшн” ХХК гүйцэтгэн ашиглалтад орууллаа. Уг шугам ашиглалтад орсоноор тухайн хэсгийн үйлдвэр, үйлчилгээний газруудын үйлчилгээний чанар сайжирахаас гадна, тухайн орчны хөрсний бохирдлыг бууруулах чухал ач холбогдолтой юм.</p> <p>Сэлэнгэ сумын нэгдсэн уурын зуухнаас сумын ЗДТГ хүртэлх дулаан, цэвэр усны шугамын ажлыг “Булган Мээж” ХХК 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөс эргэн төлөх нөхцөлтэй 167,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтад оруулаад байгаа бөгөөд нэмэлт тогооны суурилуулалтын ажил хийгдэж дуусах шатандаа байна.</p> <p>Могод сумын төвийн инженерийн шугам сүлжээний ажлын үргэлжлэлийн ажлыг “Концессын тухай хууль”-ийн барьж ашиглах нөхцлөөр “Булган Мээж” ХХК өөрийн компанийн 200,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж, 2015 оны 08-р сард ашиглалтад бүрэн оруулаад байна.</p> <p>Булган сум, 1-р баг, Мод боловсруулах үйлдвэрийн бүсэд шинээр байгуулж буй шахмал түлшний үйлдвэрийн ЦДАШ, 100кВА-ийн АТП-ны ажлыг Улаанбаатар хотын “Баян Могод” ХХК орон нутгийн байгаль хамгаалах сангийн 47,0 сая төгрөгөөр гүйцэтгэн ашиглалтад оруулаад байна.</p> <p>Говь-Алтай аймаг: Алтай хотод баригдах 1000 айлын орон сууцны хорооллын барилгын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 2300 м ЦДАШ ба дэд станц барих ажлыг 2014 оны 09 сарын 01-нээс 2014 оны 11 сарын 01 хүртэл хугацаанд орон нутгийн хөгжлийн сангийн 275 сая төгрөгөөр, “Алтай-</p>
--	--

	<p>Улиастайн ЭХС” ТӨХК, ариутгах татуургын 1380 м шугамын угсралтын ажлыг “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ 2014 оны 08 сарын 27-ноос 2014 оны 10 сарын 10 хүртэл хугацаанд орон нутгийн хөгжлийн сангийн 278 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэж ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй 1000 айлын орон сууцны хорооллын дулаан, цэвэр усны шугамын угсралтын ажлын гүйцэтгэгч “Мандал-Голомт” ХХК нь гүйцэтгэж байна. Төсөвт өртөг нь 2 990 сая төгрөг. 2014 онд орон нутгийн хөгжлийн сангаас 2 331 600 000 төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд ДХ5-ДХ12, ДХ12-ДХ20 магистралын 5 хос 1024 м шугамын угсралтын ажил хийгдсэн. 2015 онд УДДТ-ийн барилгын ажил хийгдсэн.</p> <p>Мөн Алтай-Баянхонгор чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлыг 76.2 сая долларын хөрөнгөөр концессын гэрээ байгуулан “Эрчим хүчний барилга угсралтын тресс”ХХК-тай гэрээ байгуулж бэлтгэл ажил хангагдан ажил эхлэсэн байна. Алтай-Ховдын Дарив чиглэлийн хатуу хучилттай автозамыг 356,3 сая юанийн хөрөнгөөр “Монгол ЛЗ зам гүүр”ХХК /Лунзень роуд энд бридж ХХК/ концессын гэрээгээр эхлүүлэн 2016 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Авто замын барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл 20 хувьтай байна.</p> <p>Дархан-Уул: 2015 онд улс, орон нутгийн төсвийн болон бусад хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Хабитат, Мангиртын чиглэл дэх дулааны шугамын ажил 2015 онд үргэлжлэн хийгдэж К73-К75 хооронд ø450мм хос шугам 280м урт шинээр тавигдсан. Угсралтын ажлыг “ЧММ” ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн чиглэл дэх шугам К76б худгаас хойш УГТСЭШХ хүртэл ø350мм голчтой хос дулаан, цэвэр усны шугам 800м урт шинээр угсрагдсан. Угсралтын ажлыг “ЧММ” ХХК хийж гүйцэтгэсэн болно. 2.Дархан сум 8-р баг Монгол алтны хашааны үзүүрээс 12-р сургуулийн чиглэлд 2ø250мм голчтой 200м урт дулааны шугамын шинэчлэлтийн ажлыг орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр /126,68 сая төг/ хийгдэж дуусаад ашиглалтад авсан. 3. Давхар дэд станцаас РП-9 хүртэл 1350м урт хос цахилгааны 6кв кабель шугамын угсралтын ажлыг “ДСЦТС” ХК өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. 4. Аймаг бүрт 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ төсөл арга хэмжээний багц-3 буюу байнга гэмтэл гарч байгаа 13 цэгт шугам сүлжээг шинэчлэх ажлын хүрээнд Дархан сум 8-р баг Монгол алтнаас 12-р сургууль хүртэлх дулааны ø150мм 320м урт цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажлыг “Альянс тех” ХХК /94 сая төг/ хийж дуусгасан. <p>Дорнод аймаг: Халхгол сумын төвийн дэд бүтэц инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг “Хайдро дизайн “ ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд Баян-Уул сумын дэд бүтэц, ИШС, төвлөрсөн дулаан хангамж, бие даасан ус хангамж /60.0-80.0 м3/хон/, цэвэрлэх</p>
--	--

байгууламжийн зураг төсөл /100.0 м3/хон/, угсралтын ажлыг 2014 оны 9-р сараас эхлэн “Монгол дайван” ХХК гүйцэтгэж байна.

Дорноговь аймаг: Сайншанд болон Замын-Үүд сумдын батлагдсан хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц байгуулах ажлыг АХБ-ны “Өмнөговь Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН” төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд 10 сая доллар, БНХАУ-ын “Замын-Үүд дэд бүтцийн төсөл”-ийн хүрээнд 58,8 сая долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дараах дэд бүтэц инженерийн байгууламжуудыг барьж байгуулаад байна.

Сайншанд хотод АХБ-ны санхүүжилтээр цэвэр усны 5,8 км шугам, бохир усны 5 км шугам, дулааны шугам 2,7 км, 8,4 Мвт-ын дулааны станц, хатуу хучилттай авто зам-2 км, хатуу хог хаягдал устгах машин механизмын 3 машиныг хүлээн авсан. Замын-үүд суманд АХБ-ны санхүүжилтээр цэвэр усны шугам 13,4 км, бохир усны шугам 8 км, дулааны шугам 2,9 км, ДДТ -3, Ус түгээх байр-3, Бохирын носасны станц-1, хог тээвэрлэх механизм-2, хатуу хучалттай авто зам-1 км замыг хүлээлгэн өгөөд байна. БНХАУ-ын “Замын-Үүд дэд бүтцийн төсөл”-ийн хүрээнд дулааны 90 Мвт-ын станц, цэвэр усны шугам 25,3 км, бохир усны шугам 3,2 км, саарал усны 5 км шугам, дулааны шугам 20,5 км, ДДТ-12, цэвэр усны гүний худаг -3, ундны ус цэвэршүүлэх байгууламж – 3250 м/куб/хоногт, хотын бохир ус цэвэрлэх байгууламж – 3040 м/куб/хоногт, цэвэрлэх байгууламжийн лаборатори хүлээлгэн өгсөн. “Шинэ Сайншанд” хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 8.4 мВт-ын хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлыг 2015.05.22-ны өдөр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн 2 км хатуу хучилттай авто замын ажлыг “Ди вай кэй би” ХХК гүйцэтгэн 2015.11.10-нд ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна.

Дундговь аймаг: “Сумын төвийн шинэчлэл төсөл”-өөр Өлзийт сумын айл өрх, албан байгууллагыг цэвэр бохир ус, дулаанд холбох, цэвэрлэх байгууламж, 1,7 км хатуу хучилттай авто зам барих ажлыг “Санжат” ХХК улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2014 оны 08 дугаар сарын 04-ны өдөр эхэлсэн. Дээрхи ажлын дулаан, ус хангамжийн барилга, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээний ажил, 6 хүний халуун усны барилгын ажил бүрэн хийгдсэн бөгөөд 2015 оны 10 сарын 02 өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн. Үлдэгдэл ажлын хөрөнгө төсвийн хүндрэлээс болж 1,771 км авто зам, гадна гэрэлтүүлгийн ажлыг 2016 оны улсын төсвөөр санхүүжихээр болсон. Залуус хорооллын инженерийн хангамжийн зураг төслийг 2013 онд улсын төсвийн хөрөнгөөр “Инж байгууламж” ХХК-д боловсруулж 5,0 тэрбум төгрөгөөр улсын магадлалаар баталгаажсан байна. Үүнээс тус хорооллын 6кВ-ын 459м кабелийн шугам, 2х630кВА-ийн дэд өртөө, өртөөний барилга угсралтын ажлыг “Нью энерги” ХХК орон нутгийн сангийн 292,147,928 төгрөгөөр гүйцэтгэж 2015 оны

	<p>03 сарын 20-нд ашиглалтад оруулсан. 2012 онд Мандалговь хотын дулааны станцын ТЭЗҮ боловсруулагдсны дагуу 35Мвт хүчин чадалтай дулааны станц, 4км дулааны шугам сүлжээ, дулаан дамжуулах төвийн барилга байгууламж барих ажлыг “Энерго сервис монтаж”ХХК нь гүйцэтгэж байна. 2014 онд 3км шугам сүлжээний ажил хийгдсэн. 2015 оны улсын төсвийн хүндрэлээс болоод ажил түр хугацаагаар зогссон. 2016 онд гадаадын зээл, тусламжаар үлдэгдэл ажлыг санхүүжилтийн эх үүсвэрийг судлаж байна.</p> <p>Төр болон хувийн хэвшлийн түншлэлээр “Сумдын төвлөрсөн дулаан хангамж” төслөөр Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын төвд халаалтын зуухны барилга, ANDI-20 маркийн зуух,920м гадна дулааны шугам сүлжээг угсрах ажлыг 400 сая төгрөгийн төсөвт өртгөөр “Ган-Илч”ХХК нь гүйцэтгэж, 2014 оны 12 дугаар сарын 18-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Одоогоор 1 айл, 6 төрийн байгууллагын 8 барилгын халаалтын гэрээ байгуулан ажиллаж байна. Халаалтын ажил хэвийн явагдаж байна. Азийн хөгжлийн банк, орон нутгийн хөгжлийн сан, хувийн хэвшил, иргэдийн хамтын 1 тэрбум 655 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Гурван сайхан суманд 3 км цэвэр усны, 2,1 км бохир усны, 2 км дулааны шугам, 2,5 км авто зам, гэрэлтүүлэг, явган хүний зам, ногоон байгууламж, цэвэр усны сан, ариутгах татуургын шугам сүлжээг ашиглалтад оруулсан. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж төсөл МОН/13/302”-ийн хүрээнд Дэлгэрцогт, нийтийн хэрэглээний барилга байгууламжуудыг цэвэр, бохир усны төвлөрсөн сүлжээнд холбох, хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэршүүлэх бага хүчин чадлын 60 м³ цэвэрлэх байгууламж, гүний худаг, түгээлтийн худаг, гадна цэвэр болон бохир усны шугам, 50 м³ усан сан, нөөцийн сав, носасны станцын барилга угсралтын ажлыг “Атимос” ХХК, “Гандирс” ХХК гүйцэтгэж байна.</p> <p>Завхан аймаг: Улиастай сумын Жинст багийн 60, 27 айлын орон сууцны цэвэр, бохир усны гадна шугамын шинэчлэлт, цэвэр усны 1000м³ багтаамжтай резерваур, цэвэр, бохир усны шугамын шинэчлэлтийг хийж ашиглалтанд хүлээлгэн өгсөн. 2010 онд Улиастай сумын Богдын гол багийн 60 айлын 2 барилгын гадна халаалт, цэвэр, бохир усны шугамын шинэчлэлтийг хийсэн. Улиастай сумын Өлзийт багт баригдаж байгаа 21-р зуун жишиг хороололд ариутгах татуургын 1089м гадна шугам шинээр татсан. Улиастай сумын Богдын гол багт баригдаж байгаа 40-н айлын орон сууцад халаалт цэвэр усны 150м, ариутгах татуургын 20м гадна шугам шинээр татсан. Улиастай сумын Жинст багт баригдаж байгаа 40-н айлын орон сууцад халаалт цэвэр усны 30м, ариутгах татуургын 30м гадна шугам шинээр татсан. Зэвсэгт хүчний 325-р ангийн ажилчдын 24-н айлын орон сууцны цэвэр усны шугам -250м, ариутгах татуургын 365м гадна шугам шинээр татсан. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын нэгдсэн инженерийн шугам сүлжээний ажлыг “Тэнгэрийн тэмдэг” ХХК 2014 оны 10 сард эхэлж</p>
--	---

		<p>2015 оны 11 сарын 26–ны өдөр 6,3 тэрбум төгрөгөөр барьж ашиглалтанд оруулсан. Уурын зуухны өргөтгөл, дулаан шугам сүлжээ, цэвэр усны шугам сүлжээ цэвэрлэх байгууламжийг “Тосон Очирт хайрхан”ОНӨААТҮГ-т хүлээлгэж өгсөн. Шахаж шалгах ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэхээр болсон. Баригдсан гүний худаг-2ш, 400м3-ийн 2ш резервуарын засвар, цэвэр усны гол шугам 4200м, халаалт дагасан цайрдсан цэвэр усны ган хоолой шугам -1420м, бохир усны төв шугам-5200м, 140ш – худаг, халаалтын хос шугам-1420м, уурын зуух, цэвэрлэх байгууламжийн барилга түүний тоног төхөөрөмж ашиглалтад орсон. Тэс суманд 2500м дулааны хос шугам, 2500м цэвэр усны шугам татсан.</p> <p>Орхон аймаг: Аймгийн ИТХ-аас баталсан хотын инженерийн хангамжийг сайжруулах “Инженерийн хангамжийн дэд бүтцийг 2020 он хүртэл хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөөний дагуу ажил зохион байгууллаа.</p> <p>Хотын төв цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлэх зорилгоор Өмнөдийн болон Дэнжийн цахилгааны дэд станцыг өргөтгөх, Дэнжийн дэд станцыг тэжээх цахилгаан дамжуулах агаарын шугамыг хос болгох ажлын зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн.</p> <p>Гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын системийг сайжруулах МОН23-01 төслийн хүрээнд хийгдсэн шугамд айл өрхийг холбох, ариутгах татуургын шугам нэмж татах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 байршилд УДДТ, 3362 м урт гадна шугам сүлжээний барилга угсралтын ажил хийгдэн хүлээн авч хэрэглэгчид төвлөрсөн шугамд холбогдох боломж бүрдээд байна.</p> <p>Жаргалант сумын урд хорооллыг усан хангамжийн системд холбох ажлын хүрээнд 6км шугам, 2х50м³-ийн багтаамж бүхий усан санг барьж гүний худагтаа холбох ажлыг гүйцэтгэн хэрэглэгчийг холбох нөхцөлийг бүрдүүлжээ.</p> <p>“Гэрэлтүүлэг-2020” дэд хөтөлбөрийн хүрээнд хотын гэр хорооллын гудамжийг 100% гэрэлтүүлэгтэй болсон.</p> <p>Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх зорилтын хүрээнд орон сууцны хорооллын авто замыг 85% засварлан өргөтгөж, 6.8км авто замыг шинээр тавьж ашиглалтад оруулсан байна.</p> <p>Орон нутгийн хэмжээнд хог хаягдлыг дахин боловсруулах, түүнээс эрчим хүч гаргах төсөл хэрэгжүүлэхээр зарлагдан Герман улсын технологиор "Поль Этлин" ХХК хэрэгжүүлэхээр шалгараад байна. Төслөөр орон нутгаас гарч байгаа хог хаягдлыг 100% дахин боловсруулах зорилт тавиад байна.</p> <p>Өвөрхангай аймаг: Дэд бүтцийн хүрээнд улс, орон нутаг, олон улсын байгууллагын 17951.73 төгрөгийн төсвөөр доорх ажлууд хийгдэж ашиглалтанд орсон.</p> <p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хот байгуулалтын салбар”-ын дулааны 3.5 км, цэвэр</p>
--	--	--

	<p>усны 0.5 км, бохирын усны 3.09 км шугамын ажлыг 2.7 тэрбум төгрөгөөр “ЧММ” ХХКомпани гүйцэтгэж ашиглалтанд хүлээлгэн өгсөн.</p> <p>Цахилгааны эх үүсвэрийн таслуур, залгуур суурилуулах, ХТП 630х2 1 ширхэгийг шинээр барих, 928 хүүхдийн сургуулийн цахилгааны оруулгын 140 метр хос кабель татах ажлыг улс, орон нутгийн төсвийн 223.8 сая төгрөгөөр “Хангайн энерги” ХХК гүйцэтгэж ашиглалтад өгсөн.</p> <p>Дээрх инженерийн шугам сүлжээний ажил хийгдснээр шинэ орон сууцны хороололуудын барилгажилт явагдах таатай нөхцөл бүрдэн, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, 928 хүүхдийн сургуулийн барилгын ажил хийгдэж байгаа бөгөөд хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу баригдах барилга байгууламжууд инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой болно.</p> <p>Тус шинэ суурьшлын бүсийн орон сууцны холбооны сувагчлал, холбооны зангилаа станцын барилгын ажлын зургийг Улаанбаатар хотын “Өрхтий өрөмт” ХХК гүйцэтгэж 2015 оны 01 сард хүлээлгэн өгсөн. Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Нисэхийн талбайг нүүлгэн шилжүүлж тус талбайд хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.</p> <p>Арвайхээр хотын 5-р багт баригдсан 35 айлын орон сууцны барилгыг дулааны эх үүсвэрт холбосон 70 м гадна дулааны ажлыг орон нутгийн төсвөөр 24 сая төгрөгөөр “Хашхан”ХХК угсарч ашиглалтанд өгсөн.</p> <p>Богд суманд улсын төсвийн 4,8 тэр бум төгрөгөөр “Сумын төвийн шинэчлэл хөтөлөр” амжилттай хэрэгжиж инженерийн шугам сүлжээ, байгууламжуудын ажил хийгдэж туршилт тохируулгын ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулсан.</p> <p>Сант суманд “НҮБ-ын хөдөөгийн ус хангамж ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл” амжилттай хэрэгжиж НҮБ-аас 256,04 сая төгрөг, МОН-2301 төслөөс 512,9 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 160,6 сая төгрөг нийт 929,5 сая төгрөгөөр цэвэр, бохир усны шугам сүлжээ, ундны усны гүний худаг, бохир усны цэвэрлэх байгууламжийг угсарч төсвийн байгууллагуудыг шугам сүлжээнд холбон ашиглалтад оруулсан.</p> <p>Баянгол суманд мөн “НҮБ-ын хөдөөгийн ус хангамж ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл” хэрэгжиж НҮБ-аас 269,97 сая төгрөг, МОН-2301 төслөөс 150 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 206,95 сая төгрөг нийт 626,92 сая төгрөгөөр цэвэр усны шугам сүлжээ, ундны усны гүний худаг, бохир усны цэвэрлэх байгууламжийг угсарч төсвийн байгууллагуудыг шугам сүлжээнд холбосон боловч бохир усны шугам хийх хөрөнгийн асуудал шийдэгдээгүй учир ашиглалтад ороогүй байна. 2016 оны төсөвт бохир усны шугам угсрах зардлыг суулгуулах санал тавьж байна.</p> <p>Арвайхээр хотын үерийн далангийн зургийн ажлыг “Ай Си Ти Сайн консалтинг” ХХК-иар гүйцэтгүүлж 2277 м үерийн далангийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Тэмүүн холдинг”</p>
--	--

	<p>ХХК, “Эвт уул” ХХК-аар тус тус гүйцэтгүүлж ашиглалтанд оруулсан.</p> <p>Хархорин суманд 2.7 тэрбум төгрөгөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 3,2 км үерийн далан суваг хийх, хурдас хуримтлуулах сантай шороон боомт 2-ыг байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Тэнүүн хас сар” ХХК ажиллаж ажлын гүйцэтгэл 83 %-тай байна. 2016 оны 6 сард ажил хийгдэж дуусахаар гэрээ байгуулагдсан байна. Хархорин сумын Эрдэнэтолгой баг Арцатын гэр хорооллын 500м автозамын үргэлжлэл 750м шороон далангийн ажлыг 95 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.</p> <p>Баянгол сумын Онгийн голын 63.9м модон гүүрийн ажлыг “Саруул Харгуй” ХХК 189 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.</p> <p>Гучин ус сумын модон гүүрийг “ӨВ АЗЗА” ТӨХК 43 сая төгрөгийн хөрөнгөөр засвар хийсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 4 суманд үерийн хамгаалалтын шуудуу далангийн зураг, төсөв хийгдсэн. Арвайхээр хотын үерийн далангийн зургийн ажлыг “Ай Си Ти Сайн консалтинг”ХХК-иар гүйцэтгүүлж 2277 м үерийн далангийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр “Тэмүүн холдинг”ХХК, “Эвт уул” ХХК-аар тус тус гүйцэтгүүлж ашиглалтанд оруулсан. Хархорин суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 3,2 км үерийн далан суваг хийх, хурдас хуримтлуулах сантай шороон боомт 2-ыг байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Тэнүүн хас сар” ХХК ажиллаж ажлын гүйцэтгэл 83 %-тай байна. 2016 оны 6 сард ажил хийгдэж дуусахаар гэрээ байгуулагдсан байна. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр Хужирт, Нарийнтээл сумдын үерийн хамгаалалтын далангийн зураг, төсөв хийх ажлыг “Гложекс” ХХК гүйцэтгэсэн байна.</p> <p>Хужирт сумын үерийн хамгаалалтын далангийн ажил хийгдэж Нарийнтээл сумын байр зүйн онцлогоос ажлын зургийн төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар хийгдээгүй байна. Тус сумдын үерийн хамгаалалтын шуудуу далангийн ажил хийгдсэнээр үерийн аюулаас хамгаалагдсан.</p> <p>Хот тохижилтоор нийт улс болон орон нутаг, хувийн хэвшлийн 2 тэрбум 669.7 сая төгрөгийн төсвөөр хот тохижилтын ажил хийгдсэн байна.</p> <p>Арвайхээр хотод шинээр орон сууц барьж ашиглалтад оруулсан аж ахуйн нэгжүүд өөрсдийн хөрөнгө оруулалт 139.8 сая төгрөгөөр 3653м² талбайд тохижилтын ажлыг хийсэн байна.</p> <p>Арвайхээр суманд шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий зураг төсвийг “Наран рашаан”ХХК-аар гүйцэтгүүлсэн. Барилга угсралтын хөрөнгийг шийдэх асуудлыг МУЗГазраар хэлэлцүүлэн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа G0204-МОН: Өмнөговь болон Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслөөр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. 2016 онд тендер зарлагдаж гүйцэтгэгчийг шалгаруулна.</p> <p>Өмнөговь аймаг: Манай аймгийн Ноён, Сэврэй,</p>
--	---

	<p>Гурвантэс сумдаас бусад бүх сум, аймгийн төв эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон. 2015 онд Манлай, Баян-Овоо, Ханбогд сумдууд төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Ноён, Сэврэй, Гурвантэс сумдууд БНХУлсаас эрчим хүчээ авч байна. Азийн хөгжлийн банк болон Монгол улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Өмнөговь болон Дорноговь аймгийн хот байгуулалт хилийн ойролцоо суурин газрын хөгжлийн “G0204-MON” төслөөр Цогтцэций суманд цэвэр усны 6,9 км шугам, бохир усны 5,2км шугам 100м3-ийн хоёр ширхэг усан сан, 3 ширхэг усан сан, бохир усны өргөлтийн носас станцыг барих ажлуудыг “Монинж бар” ХХК гүйцэтгэж ашиглалтанд оруулсан. Гэрээний дүн-1,1 сая ам доллар.</p> <p>Ханбогд суманд цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээ, замын байгууламжийн ажлуудыг барих ажлын гэрээг 2014 оны 09 дүгээр сарын 10-нд “Сан”ХХК-тай байгуулсан. Гэрээт ажлын хүрээнд 5,1км цэвэр усны шугам, 5км бохир усны шугам, 2 км дулааны шугам, 2 ширхэг ус түгээх байр, бохир цэвэрлэх байгууламж барих бөгөөд барилга байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. Ханбогд сумын төвийн цэвэр усны хайгуул судалгаа, эх үүсвэрийн угсралтын ажлыг “Оюу толгой” ХХК гүйцэтгэж гэрээний дүн 2,67сая ам доллар.</p> <p>“Сумын төвийн шинэчлэл төсөл-”ийн хүрээнд 2014 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цогт-Овоо сумын төвд цэвэр усны шугам 3056м, бохир усны шугам 2130м, гадна дулаан хангамжийн 1640м хос шугам, 100м3-ийн усан сан, ус түгээх байр, 1,5мВТ-ын халаалтын зуух, 50м3-ийн бохир цэвэрлэх байгууламж, автозам, явган хүний замын хамт 2км. 40ш өрхийн хашааг шинэчлэх, гудамжны гэрэлтүүлэг 84ш, халуун усны барилга, төсвийн байгууллагуудын барилгын гадна фасад, дээврийг засварлах ажлуудыг гүйцэтгэсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сард ашиглалтанд оруулаад байна.</p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Даланзадгад сумын гэр хорооллын зарим хэсгийг цэвэр, бохир усны шугаманд холбох ажлыг гүйцэтгэхээр “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжлүүлэх 2015 оны үндсэн чиглэл”-д тусгагдсаны дагуу мэргэжлийн байгууллагаар зураг төслийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгэж байна. Гүйцэтгэгчээр “Сан”ХХК ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 85 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна</p> <p>Энэхүү 2513.5 сая төгрөгийн өртөг бүхий төслийн хүрээнд 11500 м усан хангамжийн, 9156 м ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж ашиглалтанд орууллаа.</p> <p>Ханхонгор, Булган, Баян-Овоо сумдын төвийг цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбох ажлын зураг төслийг “Монхидроконстракшн”ХХК гүйцэтгэж холбогдох мэргэжлийн хүмүүс хүлээн аваад байна. Зураг төслийн өртөг 149.0 сая төгрөг</p> <p>Сэлэнгэ аймаг: “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд халаалтын төв зуухны иж бүрэн барилга байгууламж</p>
--	---

	<p>1,4 МВ хүчин чадалтай 2 ширхэг халаалтын зуух, 1500 м урт угсармал төмөр бетон тагтай үл нэвтрэх, цутгамал бетон сувагт халаалт, цэвэр усны шугам хоолойн угсралт хийгдэж сумын төвийн төв, олон нийтийн зориулалттай 10 барилгыг дулаан, цэвэр усны төвлөрсөн шугамд холбох ажил бүрэн хийгдсэн.</p> <p>Мөн шинээр цэвэр усны нөөц эх үүсвэрийн өрөмдмөл худаг гаргаж усан сан хүртэл 1750 м урт шугам татах, гэр хорооллын дундуур цэвэр усны цагираг шугам татаж 2 ш ус түгээх шугамын худаг шинээр барьсан. Ариутгах татуургын 4185 м урт шугам сүлжээ шинээр хийгдэж хуучин бохир усны соруулдаг цооногтой байсан 6 барилгыг ариутгах татуургын шугам сүлжээнд холбов. Хоногт 150м³ бохир ус цэвэршүүлэх хүчин чадалтай 2 үет хос тунгаагууртай био цэвэрлэх байгууламжийг барьсан ба шинээр хийгдсэн гүний худаг, халаалтын зуух, цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамжийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдсэн. Шинээр хийгдсэн шугам сүлжээнд сургуулийн А, Б байр болон дотуур байр, сумын Засаг даргын Тамгын газрын байр зэрэг барилгуудад дотор ариун цэврийн өрөөнүүдийг иж бүрэн засварлаж тохижуулах ажлууд бүрэн хийгдэж дууссан. Байнгын ашиглалтанд оруулахаар улсын комисс ажиллаад зарим нэг дуусаагүй гадна шугамын ажлыг бүрэн дуусгах мөн гадна цахилгаан хангамжийн ажилд гарсан зөрчлийг арилгах зэрэг хугацаатай үүрэг даалгавар өгөөд байна. Үүрэг даалгаврыг хугацаанд нь хийж гүйцэтгээд улсын комисст хүлээлгэж өгсөн. Сэлэнгэ аймгийн 9 сумын 0.4 кВ-ын ЦДАШ-ын шинэчлэлт, тоолуур төвлөрүүлэлтийн ажлын гүйцэтгэлийг шалгаж танилцан улсын комисст үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч ДСЦТС ХК-д хүлээлгэн өгөв. Нийт 771 айл өрхийг 0.4 кВ-ын СИП ЦДАШугам,тоолуур төвлөрүүлэлтэнд хамруулж, хүчдлийн түвшинг сайжруулсан. Сүхбаатар суманд “1000 айлын орон сууц” төслийн инженерийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор “Набсан”ХХК-ийн гүйцэтгэж байгаа инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэй. Ус дулаан дамжуулах төв УДДТ-1, УДДТ2-ийн барилга угсралтын ажил дууссан. Ажлын нийт гүйцэтгэл 85% хувьтай. УДДТ-1 ба 2-ын тоног төхөөрөмж угсралт 80% ба УДДТ-3-ын барилга угсралтын ажил 80%. Сайхан сумын 40 айлын амины орон сууцны хорооллын дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний ажилд 2014-2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 975.0 сая төгрөг тусгуулсан бөгөөд “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан. Сүхбаатар сумын 4–р багт Шүдэнзний арын айлууд руу гадна дулаан цэвэр усны гол шугам татах ажлыг “Жаргал Констракшн”ХХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан. Алтанбулаг сумын төвийн усан хангамжийн системийг “Алтанбулагийн чөлөөт бүс”-ийн цэвэр усны гол шугамтай холбох ажлыг “Маргад Монгол” ХХК концессийн гэрээгээр хийж гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн.</p> <p>Төв аймаг: Зуунмод хотын 1000 айлын орон сууцны</p>
--	---

	<p>хорооллын инженерийн шугам сүлжээний гадна ариутгах татуурга, гадна дулаан, гадна цэвэр усны ажлыг барилга угсралтын “Нишин илч” болон “Набсан” ХХК-ууд түншлэл гүйцэтгэн хүлээлгэн өгөөд байна. Үүнд дараахи ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Бохир усны $\varnothing 150-450$ диаметртэй 3290 у/м шугам угсарч 123 худаг тоноглогсон, мөн цэвэр усны $\varnothing 159$ 2800 у/м шугам угсарч 8 галын гидрант 7 худаг тоноглогсон, дулааны 650 у/м сувгийн ажлын хамтаар шугам хоолойг угсарч 14 худаг тоноглогсон. Гүйцэтгэл 100 хувь. Дээрхи ажилд улсын төсвөөс 2,8 тэрбум төгрөг зарцуулсан</p> <p>Энэ ажлын хүрээнд ЭХЯ-ны зохицуулах зөвлөлөөс Зуунмод хотын 1000 айлын орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан гүйцэтгэгчээр "Аркади"ХХК шалгаран 3,4 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Энэ ажлын хүрээнд 10 кВт-ын хуваарилах байгууламж 1ш, 4х800 кВа-ын 10/0,4кВт-ын ХТП, Зуунмод 35/10 кВт-ын худаарилах байгууламжаас 1000 айлын хуваарилах байгууламж хүртэл 1,8 км XLF-240 кабель, хуваарилах байгууламжаас 4х800 кВа-ын 10/0,4кВт-ын ХТП хүртэл 1,1 км XLF 185-ын кабель шугамын ажил хийгдсэн. Одоо хуваарилах байгууламж болон ХТП-ний тоноглол угсрах ажил хийгдэж байна. Санхүүжилт 2015 онд 1,8 тэр бум төгрөг санхүүжихээс 540 сая төгрөг санхүүжсэн. Хийсэн ажлын гүйцэтгэлээр 2,0 тэрбум төгрөгийн ажил хийгдээд байна. Дээрх шалтгаанаар 2015 оны 10-р сарын 15 хүртэл гэрээг сунгасан байна.</p> <p>Дулааны эх үүсвэр буюу зуухны барилгын ажлыг Азийн хөгжлийн банк болон улсын төсвийн нийт 1,4 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэйгээр барилга угсралтын “Жаргал констракшн” гүйцэтгэж байна. Энэ ажлын хүрээнд 18*30 метрийн харьцаатай 2 давхар барилгад 2,8 МВт хүчин чадалтай 3 зуухыг тоноглож ажиллуулна. Уг 3-н зуух нь 1000 айлын хорооллын орон сууц болон олон нийтийн барилгуудын халаалт болон хэрэгцээний халуун усаар хангана.</p> <p>Увс аймаг: Увс аймгийн Улаангом, Тэс сумдын инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц инженерийн байгууламжуудыг барьж байгуулаад байна. Улаангом хотын 11-р багийн ДДТ-1, 4-р багийн ДДТ-7-ийн 2-р хэлхээний дулаан халаалт, цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажил, Улаангomoос Завхан аймгийн Сонгино сум хүртлэх хатуу хучилттай авто замын ажлын 190 км зам угсралтын ажил, Улаангом хотын төвд "Гудамж төслийн" 2014-2015 онд нийт 11.4 км хатуу хучилттай авто замын ажлуудыг “Шинжа-Шинфа” ХХК гүйцэтгэн 2015 онд ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна. Улаангом хотын 3-р багийн "Галдан бошиг" Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн.</p> <p>Тэс суманд Тэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах ажил,цэвэр усны 2,6км шугам, бохир усны 2,3 км шугам, дулааны шугам 2,6 км, 1,4мвт-ын 2 хос зуух, 50м3 усан сан,8 барилгад шинээр дулааны узель,тогооны барилгын засвар, хоногт 100м³-ын</p>
--	--

	<p>био цэвэрлэх байгууламж, 2 насосны станц шүүрүүлэх талбай, цэвэрлэх байгууламж, уурын зуух, насосны станцын чиглэлд 1км гадна цахилгааны шугам, цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил, гүний худаг болон гаражийн барилга угсралтын ажил, Тэс сумын төвийн гудамжны 2,5км гадна гэрэлтүүлэг болон явган хүний зам, нутгын удирдлагын ордны барилга угсралтын ажил хийгдээд байна.</p> <p>Ховд аймаг: Ховд аймгийн төвд дулааны 2 дахь эх үүсвэр болох 35 Мвт хүчин чадалтай дулааны станц 2014 онд ашиглалтанд орсон. Мөн “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд Зэрэг сумын төвд дулааны нэгдсэн зуух, дулааны шугам сүлжээний ажил эхэлсэн. 2016 онд үргэлжлүүлэхээр Засаг даргатай гэрээ байгуулсан.</p> <p>2014 онд “Эрчим хүчний үр ашиг” төслийн хүрээнд Ховд аймгийн Жаргалант сумын 5-р цэцэрлэгт дулааны алдагдлыг бууруулах засвар шинэчлэлтийн ажил хийгдэж ашиглалтад орсон. 2015 онд мөн “Эрчим хүчний үр ашиг” төслийн хүрээнд Ховд аймгийн Дуут суманд 15 ортой эмнэлгийн барилгад дулааны алдагдлыг бууруулах засварын ажил амжилттай хийгдэж ашиглалтад орсон. Жаргалант сумын ерөнхий боловсролын 2-р сургуулийн барилгын дулаан алдагдлыг бууруулах засварын ажил эхэлсэн 2016 онд үргэлжлэн хийгдэнэ.</p> <p>2012 оны 7-р сараас эхлэсэн Ховд аймгийн Жаргалант сумын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг “Ховдын тулга” ХХК гүйцэтгэж байна. Цэвэрлэх байгууламжийн ажил блок ёмкостын цутгалтын ажил дууссан, үйлдвэрийн барилга, сараалжийн барилга, зуухны барилгын засварын ажил дууссан, манаачийн байр, гүний худгийн ажлууд дууссан, халаалтын тогоо суурилагдсан, технологийн шугам сүлжээний ажил дуусан боловч тоног төхөөрөмж суурилагдаагүй ажил 85 хувьтай зогссон байдалтай байна. “Хүчит чулуут” ХХК-ийн гүйцэтгэж байгаа “Талын хашааны цэвэр, бохир усны шугам сүлжээний ажил”-ын хүрээнд 2014 онд 4,7 км бохир усны шугамын ажил хийгдэж үүнээс 3,2 км, 2015 онд 1.8 км шугамын ажил хийгдэж 3.3 км, нийтдээ 6,5 км шугам шинээр ашиглалтанд орлоо.</p> <p>2014 онд Ховд аймгийн Жаргалант сумын “Цэвэр усны насосны станц, цэвэр усны шугамын өргөтгөл, шинэчлэлт” ажлын хүрээнд цэвэр усны насосны станц, 2ш гүний худаг, цэвэр усны 4,8 км шугам сүлжээ ашиглалтанд орсон. 2015 онд “Талын хашааны цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, шинэчлэлт” ажлын хүрээнд 500х2 м³ усан сан, 9,9 км цэвэр усны шугам сүлжээ ашиглалтад орлоо. Үүнээс гадна аймгийн хэмжээнд ундны болон мал аж ахуйн хэрэгцээнд зориулж 2014 онд нийтдээ 8, 2015 онд 2 гүний өрөмдмөл худаг ашиглалтанд орсон.</p> <p>Хөвсгөл аймаг: Төвлөрсөн халаатын системтэй 7 сумын шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг шинэчилж, төсвийн байгууллагын түлшинд нүүрс хэрэглэж байна. Алаг-Эрдэнэ, Арбулаг, Галт сумдын төвлөрсөн халаалтын системийн зураг төслийг</p>
--	--

	<p>боловсруулан хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хүргүүлсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Мөрөн сумын цэвэрлэх байгууламжийг бүрэн биологи цэвэрлэгээтэй болгох өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдэхээр зураг төсөв бэлэн болсон 2016 онд ажил хийгдэнэ. УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгийн санаачилгаар гэр хорооллын 800 айл өрхийг цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлын хүрээнд 2014 онд Мөрөн сумын 6-р багийн 320 айлыг цэвэр бохир усны нэгдсэн системд холбох ажил хийгдэж, 2015 онд 7,13 дугаар багийн 160 айл өрхийг цэвэр бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг “Монгол Дайвун”ХХК гүйцэтгэж байна.</p> <p>Хэнтий аймаг: Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3-р багийн нутагт баригдаж буй “Шинэ Өндөрхаан” хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хөх бүрдний эх” ХХК бохирын даралттай хос шугам 1611м, өөрийн урсгалтай шугам 3561м, цэвэр усны шугам 1636м, дулааны 922м шугам сүлжээ ба 8.4мвт-ын уурын зуухны барилгыг 4.5 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Мөн Хэрлэн сумын 4-р багийн нутаг дэвсгэр дахь 50 айлын жишиг хороолол гадна бохирын 384 м шугам сүлжээний ажил, 40 айлын жишиг хорооллын дулаан хангамжийн шугам сүлжээний ажлуудыг орон нутгийн хөгжлийн сангийн 240,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар “Хэнтий ус” ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн Хэрлэн сумын 4-р багийн нутаг дэвсгэр дахь 20 айлын хаус хорооллын иж бүрэн инженерийн шугам сүлжээний ажлыг “Эх хэрлэн ус” ХХК 220 сая төгрөгөөр хийж гүйцэж тус тус ашиглалтад оруулаад байна. Мөн Хэнтий аймгийн Биндэр сумын шинэчлэл төслийн ажлын хүрээнд бохирын 1832м шугам, цэвэр усны 3100м хос шугам, дулааны 3100м иж бүрэн инженерийн шугам сүлжээний ажил 2.5 тэрбум төгрөгийн ажлыг “Монгол дайван” ХХК хийж гүйцэтгэж байна. Чингис хотын гэр хороололд 16 ус түгээх байр байдгаас 14 ус түгээх байрыг төвлөрсөн шугам сүлжээнд холбоод байна. Мөн айл өрх аж ахуйн газруудад график гарган тоолууржуулах ажлыг хийж байна. Түүнчлэн 3-р цэцэрлэг, Хэнтий аймгийн поркурорын газар, ШШГА, цагдан хорих, Биг оргил худалдааны төв, “Алсын солонго” худалдааны төв, ясли, нэгдсэн эмнэлэг гэх мэт аж ахуй нэгж байгууллагуудад тоолуур суурилуулаад байна.</p> <p>Мөн тоолуурын суурин эталон тоног төхөөрөмжийг суурилуулж лаборатори байгуулан оруулж үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Улсын төсвийн 4,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын 3-р багт баригдаж буй “Шинэ Өндөрхаан” хорооллын иж бүрэн инженерийн шугам сүлжээний ажил болон Хэрлэн сумын цэвэрлэх байгууламжийн өөрийн урсгалтай бохир усны дан шугамыг хос шугам болгож өргөтгөн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх ажлыг 2015 онд “Хөх бүрдний эх” ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар баригдах цэвэрлэх байгууламжийн зураг төслийг “Наран рашаан” ХХК гүйцэтгэж байна. Зураг төслийн ажлын</p>
--	---

		явц 80% байна.
8	4.4.2.7.Улаанбаатар хотод “Гацуурт”, “Буянт-Ухаа” гүний усны эх үүсвэр, “Туул усан цогцолбор” далан барьж ашиглалтад оруулах	<p>Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх “Яармаг эх үүсвэр” төсөл хэрэгжиж дууссан бөгөөд төслийн хүрээнд Яармагт шинээр баригдах орон сууцны хотхон, гэр хорооллын 120 мянган өрх цэвэр усаар хангагдах юм. БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Койка олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл нь 22.6 сая ам.долларын өртөгтэй. 2011-2013 оны хооронд 3 жилийн хугацаанд хэрэгжиж, хоногт 20 000м3 ус олборлох хүчин чадалтай эх үүсвэр, /2 гүний худаг/, насосны станц, 2 усан сан, 5.3 км урт дамжуулах шугам хоолой тоноглох ажлууд хийгдсэн.</p> <p>Монгол, Япон улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын ундны усыг нэмэгдүүлэх Гачуурт эх үүсвэр” төслийн ажил нь 2012-2014 оны хооронд хэрэгжсэн. Энэ төслөөр Туул голын ай савын Гачууртын Мойлтын тохойд 21 ш гүний худаг шинээр барин, 7,2 км цуглуулах шугам, 3000*2 м3 усан сан, халдваргүйжүүлэх байгууламж, дамжуулах ф700 мм шилээр хүчитгэсэн пластик нийлмэл хоолойгоор Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан санд нийлүүлэх шугамын ажлыг дуусган байнгын ашиглалтанд оруулаад байна.</p> <p>Туул усан цогцолбор” далан барих:</p> <p>“Туул усан цогцолборын ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгаа”, Улаанбаатар хотын усны нөөцийн мастер төлөвлөгөөг 2011-2012 онд Престиж групп ХХК, БНСУ-ын KOICA байгууллага тус тус боловсруулсан байна. Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хурлаар 2013 оны 06 сард уг асуудлыг хэлэлцэж, Туул голын 2 дахь хөндлүүр дээр Туул усан цогцолборын барилга угсралтын ажлыг яаралтай эхлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.</p> <p>“Туул усан сан барих төсөл”-ийг Монгол улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтаар батлагдсан тул НИТХ-ын 2014 оны 21/31 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-аас хасагдсан.</p>
9	4.4.2.8.Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулах	<p>Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд хор нөлөөгүй технологиор шинэчлэн сайжруулахаар дунд болон урт хугацааны стратеги баримтлан ажиллаж байна.</p> <p>Дунд хугацааны стратеги төлөвлөлтийн шатанд Төв цэвэрлэх байгууламжид шинээр 2 ширхэг цацраг тунгаагуур нэмж барих болон биоцөөрмийг шинэчлэн барих ажлыг “Сайн констракшн” ХХК 2013 оноос эхлэн үргэлжлүүлэн барьж байна. Одоогийн байдлаар биоцөөрөм барих ажлын шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж дуусаад байна. Мөн биоцөөрмийн хөрс хуулалтын ажил 100 хувь хийгдсэн бөгөөд бусад ажил нь он дамжин 2016 онд хэрэгжихээр болоод байна.</p> <p>НХОГ, НМХГ болон "УХАТ" ХХК-ний инженерүүд хамтран Төв цэвэрлэх байгууламжийн дугуй резерваурын бетон хийцний дүгнэлт гаргуулах асуудлыг хамтран хэлэлцэж, мэргэжлийн</p>

		<p>байгууллагаар дүгнэлт гаргуулсан. Гүйцэтгэгч "УХАТ" ХХК нь зураг төслийн ажлыг 11 дүгээр сард боловсруулж дууссан бөгөөд Барилгын хөгжлийн төв дээр экспертизээр магадлагаа хийгдэж байна.</p> <p>Урт хугацааны стратеги төлөвлөлтийн хүрээнд: Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага нь Улаанбаатар хотын цэвэр, бохир усны мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг шинэчлэх урьдчилсан ТЭЗҮ, 2012.08-р сард боловсруулж дуусгасан. 2014 онд Нийслэлийн зүгээс Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлын зураг төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний хөрөнгийг шийдвэрлэсэн.</p> <p>Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, шинэчлэх ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх компаниар БНФУ-ын "Артелиа Вил энд Транспорт" ХХК шалгарч, 2015.11.04, 2015.12.16-нд хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. ТЭЗҮ-г эцсийн байдлаар 2016.01-р сард хүлээлгэн өгнө.</p> <p>Засгийн газрын 2015.11.16-ны хуралдаанаар Улаанбаатарт шинээр цэвэрлэх байгууламж барих төслийг концессоор хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад концессын барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэх "Улаанбаатар хотод шинээр цэвэрлэх байгууламж барих-250 000 м³/хоног хүчин чадалтай төсөл"-ийг концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд, Хөрөнгө оруулалтын газарт даалгасан. Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>"Саарал усны систем. Ерөнхий шаардлага" MNS BS 8525-1:2015 стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015.06.25-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор хэлэлцэн баталсан.</p> <p>Цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах зорилгоор "Цэвэрлэгдсэн усыг усалгаанд ашиглах заавар" багц стандартын төслийг "Монгол усны форум-Ус хэлц ТББ" боловсруулж байна.</p>
10	4.4.2.9.Улаанбаатар хотын хэмжээнд хаягдал (саарал) ус, лагийг дахин ашиглах технологийн шинэчлэл хийх	<p>Нийслэлийн зүгээс Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлын зураг төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний хөрөнгийг шийдвэрлэж олон улсын нээлттэй тендер зарлаад байна. Дээрх зөвлөх үйлчилгээний ажлын зургийн даалгаврыг батлуулсан бөгөөд тус ажлын даалгаварт Улаанбаатар хотын хэмжээнд хаягдал (саарал) ус, лагийг дахин ашиглахыг тусгасан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Ус сувгийн удирдах газар болон Улаанбаатар-Усан Цэнэгт Цахилгаан станц ХХК-тай хотын бохир усыг цэвэрлэж дахин ашиглах хамтын ажиллагааны гэрээг байгуулаад байна.</p>
4.4.3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд		
11	4.4.3.1. "100 мянган айлын орон сууц" төслийн хүрээнд Улаанбаатар хотын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 35	<p>Гэр хорооллын дахин төлөвлөлт хийгдэх 1, 2, 3,4 дүээр ээлжинд төлөвлөлтийг 24 байршил дээр 77-н блок болгосон талбайд ХЕТ боловсруулах болон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулан ажиллаж байна. Дахин төлөвлөлтийн блокуудад төсөл</p>

<p>байршилд 80 мянгаас доошгүй айлын орон сууцны цогцолбор хороолол, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдэд 25 мянга хүртэлх айлын орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, бие даасан болон төвлөрсөн эх үүсвэртэй инженерийн дэд бүтэц, ногоон байгууламжийн хамтаар барих</p>	<p>хэрэгжүүлэгчээр сонгон шалгарсан 36-н аж ахуйн нэгжийн ХЕТ-г "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлага"- тай уялдуулан холбогдох норм, дүрмийн дагуу хянан батлаад байна. Дээрхи батлагдсан ерөнхий төлөвлөгөө бүхий дахин төлөвлөлтийн 36 блокт 55613 айлын орон сууц, 26 сургууль, 36 цэцэрлэг байхаар төлөвлөгдсөн байна.</p> <p>“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2014 оны 263 дугаар тогтоол гарч шинэ хороолол, хотхонд 112,373 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар БХБЯ, ЭХЯ-ны төслийн нэгжүүд хариуцан шугам сүлжээг барьж байгуулах ажлыг хийж байгаа бөгөөд, гэр хорооллын инженерийн шугам сүлжээг барихад 84,536 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шугам сүлжээг барьж байгуулах ажлыг Нийслэлийн Инженер Дэд бүтэц төсөл хариуцан гүйцэтгүүлж байна. Үүнд: - Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны гэр хорооллын цахилгааны ХБ 4ш, 9ш хаалттай дэд өртөө барьж байгуулах, өндөр хүчдэлийн 5900м кабель шугам, Дулааны эх үүсвэр -2 ш, дулааны ф80/300мм-ийн 2010 метр шугам, Усан хангамж ф500мм 1800 метр, ф80/300мм-ийн 3080 метр, ариутгах татуургын ф300 мм 1050 метр, ф400/200мм-ийн 1310 метр шугамын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70%-тай байна.</p> <p>- ЧД-ийн 13,15-р хороо, Цахилгааны хаалттай дэд өртөө 2х630КВА-1ш, 2х800КВА - 3ш, 3х185-ийн 1980 у/м кабель шугам, Дулаан хангамжийн эх үүсвэр уурын зуухны барилга -2ш, хатуу түлшний халаалтын тогоо -6ш, хэрэгцээний халуун усны ялтсан дулаан солилцуур-2 ком, Дулааны шугам сүлжээний Ф80/200 мм-ийн голчтой шугам 738 метр, Ф50/150 мм-ийн голчтой шугам 2410 метр, Цэвэр усны Ф32/150 мм-ийн 1400 метр шугам, Бохир усны Ф150/200мм-ийн 800 метр шугамын угсралтын ажил 70%-тай явагдаж байна.</p> <p>- Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын Цахилгааны хаалттай дэд өртөө /ХТП/-г 20 комплект, 10 кВ-н 28 км кабель шугам тавих, 10 кВ-н ХБ 2 ком, 4ш ус дулаан дамжуулах төв, цэвэр усны ф100-300мм-ийн 3216 метр шугам, бохир усны ф150-300мм-ийн 1706 метр шугамын барилга угсралтын ажил 90%-тай явагдаж байна.</p> <p>- СХД-ийн 10-р хороо, 10 кв-ын ХТП-2 ш, цахилгааны 10кв-ын 1.5км кабель шугам, Дулааны ф65/200мм-ийн 924 метр шугам, Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлал, Усан хангамж ф32/150мм 871 метр шугам, ариутгах татуургын ф150/300мм-ийн голчтой 3100 метр шугамын барилга угсралтын ажил 50%-тай явагдаж байна.</p> <p>-“Дэд бүтэц” төслийн хүрээнд: Буянт-Ухаа орон сууцны хороолол/ОСХ/-ын 10 хэсгийн 10 ЦТП, гадна цахилгаан хангамжийн ажлаас Ус, дулаан дамжуулах төв /ЦТП-11/-ийг бүрэн хийж гүйцэтгэн 2015.04.23-нд улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан. Ирээдүй цогцолбор хорооллын бохир</p>
--	--

		<p>усны Ф150-500 мм-ийн 4,9 км гол шугамын болон бохир усны насосны станцын барилгын ажлыг бүрэн дуусгаж 2015.12.23-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Буянт-ухаагийн 20000 м³/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилгын ажил хийгдэж байна.</p> <p>Буянт Ухаа хороололд ТОСК-ийн эхний ээлжийн 10 барилга бүх шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийн ажил дуусч ашиглалтанд орсон. ГХХГ-аас гаргасан дахин төлөвлөлтийн дагуу 8 байршилд техникийн нөхцөл олгосон.</p> <p>Нийслэлд 2010 онд 9507 айлын, 2011 онд 10972 айлын, 2012 онд 10399 айлын, 2013 онд 15355 айлын, 2014 онд 20820 айлын, 2015 онд 20713 айлын, нийтдээ 87766 айлын орон сууц ашиглалтад орсон байна.</p> <p>Аймгуудад 2010 онд 392 айлын, 2011 онд 377 айлын, 2012 онд 1014 айлын, 2013 онд 4945 айлын, 2014 онд 3924 айлын, 2015 онд 5627 айлын, нийтдээ 16279 айлын орон сууц ашиглалтад орсон байна.</p> <p>Орон сууц худалдаж авах боломжгүй зорилтот бүлгийн иргэдийг орон сууцжуулах зорилгоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн төслийг боловсруулж, ЗГ-ын 2015 оны 248 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ТОСК-ын захиалгаар аймаг, нийслэлд баригдаж ашиглалтад орсон 929 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг ЗГ-ын 2016 оны 1-р сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.</p>
12	4.4.3.2. Шинэ орон сууцны цогцолбор хорооллын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар ашиглалтын байдлын зураглал хийх, газар ашиглалт, үл хөдлөх хөрөнгийн судалгаа гаргах, зохистой төлөвлөлттэй цогцолбор хороолол барих	<p>Нийслэлийн Засаг даргын А/539-А/546 дугаар захирамжаар Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан компаниуд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх байршилд дэд бүтэц бүхий орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн оролцоотойгоор боловсруулан НИТХ-аар батлуулан, хэрэгжүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>Барилга, хот байгуулалтын яамнаас Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Аймаг бүрд 1000 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэхээр улсын төсвийн хөрөнгөөр Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хэнтий аймгийн төвүүдэд нийгмийн дэд бүтцийн хамт баригдах орон сууцны хорооллыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулаад байна. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттайгаар улсын төсөвт тусгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>

13	4.4.3.3. Гэр хорооллыг нэн тэргүүнд дэд бүтэцтэй болгоход улсын төсөв болон бусад орлогын үүсвэрийг зориулах, түүнчлэн гэр хорооллын айл өрхийг дэд бүтэцтэй өртөг нэмэгдсэн газраа барьцаалан орон сууцтай болох, орон сууцны зээлд хамрагдах бололцоогоор ханган амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэх	Монгол улсын Засгийн газрын 2013 оны 118, 2014 оны 263 дугаар тогтоол гарч гэр хорооллын байршлуудад барилга байгууламж шугам сүлжээг барьж байгуулахад нийт 84,5 тэрбум төгрөг тусгуулан зураг төсөл барилга угсралтын ажлууд хийгдэж эхлээд байна. Дахин төлөвлөлтийн блокуудад төсөл хэрэгжүүлэгчээр сонгон шалгарсан 36-н аж ахуйн нэгжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг баталсан. Тухайн байршлуудад төсөл хэрэгжүүлэгчээр сонгогдсон аж ахуйн нэгжүүд иргэдийн оролцоотойгоор газар чөлөөлөлт, иргэдийг түр суурьшуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж байгаагаас 8 аж ахуйн нэгж барилга эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлөө авсан. 2014 оны НИТХ-ын 19/23 дугаар тогтоолоор “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 4 дүгээр ээлжийн байршил батлагдсан бөгөөд байршлуудыг 10 хэсэгчилсэн талбай болгон хувааж, блок тус бүр дээр ажлын даалгавар боловсруулж, 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталгаажуулсан.
14	4.4.3.4. Улаанбаатар хотын гэр хорооллыг инженерийн дэд бүтэцтэй болгох, гэр хорооллын өрхүүдийг орон сууцанд орох нөхцөлийг бүрдүүлэхдээ хот төлөвлөлтийн судалгаанд үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 32100-аас доошгүй орон сууцыг ашиглалтад оруулах	Гэр хорооллын айл өрхийг амины орон сууцны хороолол болгон дэд бүтцэд холбох зорилгоор Гудамж төслөөс зураг төслийн НьюУрванизм ХХК-д дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан, холбооны шугам сүлжээний ажлын зураг төслийг гүйцэтгэн, МУ-ын ЗГ-ын 263 тоот тогтоолд УДДТ 4 ш.холбооны сувагчлалыг хийхэд 1,804 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны төслийг хэрэгжүүлж буй байршлуудаас СХД, БГД, БЗД, СБД, ЧД-үүдэд “Херахолдинг”, “Назу” групп, “Асар-өргөө”, “Буурал сутаг” “Цэлмэг-Ази”, “Гангар инвест” “Баганат-өргөө”, “Гранд лайн” “Жиди”, “Асар-Өргөө”, “Бэрэн групп”, “Моннис”, “Бүрд”, Баянхошуу дэд төв, “Очирням проперти”, “Ди Ви Жи Эйч”, АХБ-ны “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”, “Бэрэн лэнд девелопмент”, “Тоб групп” ХХКомпаниудын ажлууд хийгдэж байна. Засгийн газраас 2013 оны 200 дугаар тогтоолоор “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ыг батлуулан, ашиглалтад орсон болон ашиглагдаж байгаа 80 м2 хүртэл талбайтай орон сууцыг худалдан авах иргэдэд жилийн 8±1 хувийн хүүтэй, 20 хүртэл жилийн хугацаатай зээлийг арилжааны банкуудаар дамжуулан 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс олгож эхэлсэн. Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Орон сууцны ипотекийн ерөнхий журам”-д Засгийн газрын 2014 оны 151 дүгээр тогтоолоор “Аймаг, сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, дэд бүтэц / цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга/-ийн шийдэл бүхий амины орон сууцыг худалдан авах иргэд болон хот төлөвлөлт, барилгын норм, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн өөрийн өмчлөлийн газар дээр амины орон сууц барьсан иргэдэд энэхүү зээлийг олгоно.” гэсэн заалтыг шинээр нэмсэн. Монголбанкнаас гаргасан мэдээгээр 2015 оны 12 дугаар сарын 04-

		ний өдрийн байдлаар банкууд 19413 зээлдэгчийн нийт 581 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, 8 хувийн хүүтэй ипотекийн зээл рүү шилжүүлсэн байна. Түүнчлэн орон сууц шинээр худалдан авахыг хүссэн 41055 иргэнд 2.2 их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгохоор шийдвэрлэсэн байна.
15	4.4.3.6. Улаанбаатар хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоо байгаа гэр хорооллын 557,8 га газрыг чөлөөлөх	НИТХ-ын 4 удаагийн тогтоолоор Гэр хорооллыг дахин төлөвлөлтийн 24 байршлын 77 хэсэгчилсэн талбайд 1193,4 га газрыг хамруулаад байна. Гэр хорооллыг дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9,11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Орон сууцны 7 хороолол төслийн дэд бүтцийн трасст өртсөн нийт 42 иргэн, аж ахуйн нэгжийн газрыг чөлөөлсөн.
16	4.4.3.7. Улаанбаатар хотын “Шинэ Яармаг”, “Буянт-Ухаа”, “Баянголын ам”, “Ирээдүй хороолол”, “Ургах наран”, “Эрин хотхон” зэрэг хүн амын шинэ суурьшлын бүсэд 20000 орчим айлын орон сууц, Дархан хотын 13 дугаар хороололд 2000 айлын орон сууц барих	“Шинэ Яармаг”, “Буянт-Ухаа” хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийт 56488 айлын орон сууц, “Ирээдүй хороолол”-320 айлын орон сууц, “Ургах наран хороолол”-602 айлын орон сууц, “Эрин хороолол”-1368 айлын орон сууцны эскиз зураг төслийг тус тус баталсан. Үүнээс: -“Буянт-Ухаа” хороололд- 1728 айл бүхий 28 блок орон сууцны барилга, 324м ² талбай бүхий үйлчилгээний зориулалттай барилга, 60*2 ортой хүүхдийн цэцэрлэг 2, “Шинэ Яармаг”-д 400 айл 10 блок орон сууцны барилга, “Ургах наран”-д 96 айл бүхий 2 блок орон сууцны барилга, 200 хүүхдийн цэцэрлэгийг тус тус барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах комисс ажиллаж хүлээн авсан. 2015 онд дээрх хорооллуудын инженерийн дэд бүтцийг барих чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: -Буянт-Ухаа орон сууцны хороолол/ОСХ/-ын 10 хэсгийн 10 ЦТП, гадна цахилгаан хангамжийн ажлаас Ус, дулаан дамжуулах төв /ЦТП-11/-ийг бүрэн хийж гүйцэтгэн 2015.04.23-нд улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авсан. Ирээдүй цогцолбор хорооллын бохир усны Ф150-500 мм-ийн 4,9 км гол шугамын болон бохир усны насосны станцын барилгын ажлыг бүрэн дуусгаж 2014.12.23-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Буянт-ухаагийн 20000 м ³ /хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилгын ажил хийгдэж байна.
17	4.4.3.8. газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй, бат бэх чанараа хангахгүй болсон барилга байгууламжийг буулгаж шинээр барьж байгуулах	Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй болсон талаар мэргэжлийн хяналтын байгууллагын шийдвэр гаргуулах шаардлагатай орон сууцны 497 барилга ашиглагдаж байгаагийн 171 барилга нь орон нутагт, 326 барилга нь нийслэлд байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Американ дэнж" сууц өмчлөгчдийн холбооны харьяа нийтийн зориулалттай орон сууцны 60, 61, Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Ажилчин" сууц өмчлөгчдийн холбооны харьяа нийтийн зориулалттай орон сууцны 25, 26 дугаар барилгууд

		<p>ашиглалтын шаардлага хангахгүй болохыг албан ёсоор тогтоосон байна.</p> <p>Орон нутагт ашиглагдаж байгаа 171 барилгаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон нь албан ёсоор тогтоогдсон барилга байхгүй байна.</p> <p>“Орон сууцны тухай хууль”-д ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөх асуудлаар тусгайлан заалт оруулж, 2011 онд УИХ-аар батлуулсан.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцныг буулгах, шинээр барих үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль, эрх зүйн баримт бичгүүд тухайлбал, “Орон сууцны тухай хууль”, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 322 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны барилга ашиглалтын шаардлага хангахгүй болохыг тогтоох аргачлал”-ын холбогдох заалтууд хоорондоо зөрчилдөж байгаагаас орон сууцны барилга ашиглалтын шаардлага хангаж байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргах ажил зогсонги байдалтай байна гэсэн дүгнэлтийг ажлын хэсгийн 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 3 дугаар хуралдаанд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас танилцуулсан.</p> <p>Үүний дагуу Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 322 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны барилга ашиглалтын шаардлага хангахгүй болохыг тогтоох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж, БХБСайдын 2013 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 127 дугаар тушаалаар батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах журам”-ыг баталсан.</p> <p>Эдгээр эрх зүйн баримт бичгүүд батлагдсанаар, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг дахин төлөвлөж барилгажуулах эрх зүйн үндэс бүрдсэн.</p> <p>2015 онд нийтийн зориулалттай орон сууцны 129 барилгад газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ хийж, паспортжуулахаар төлөвлөгдсөнөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 129 барилгад үзлэг хэмжилт судалгаа хийж, 91 барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварын үнэлгээг бүрэн гаргаж паспортжуулаад байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Эрх шилжүүлэх тухай” А/612 дугаар захирамжаар нийслэлийн төсвөөс 100 сая төгрөгийн санхүүжилтээр “Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлэх ажилд шаардлагатай техник тоног төхөөрөмж болох Барилга байгууламжийн төмөр бетон бүтээцийг шалгах цахилгаан соронзон радарын багаж NJJ-105, Барилга байгууламжийн төмөр бетон бүтээцийн бат бэх шалгагч алх DigiSchmidt, Барилга байгууламжийн төмөр бетон бүтээцийн арматурын байрлал, хамгаалалтын үеийн зузааныг тодорхойлогч багаж Profometer PM 630 зэрэг тоног төхөөрөмжийг 2015 оны 03 дугаар сарын</p>
--	--	--

<p>Орон сууцны чиглэлээр аймгуудад хийгдсэн ажлууд:</p>	<p>12-ны өдөр хүлээн авсан.</p> <p>Архангай аймаг: Эрдэнэбулган суманд Төрийн орон сууц корпорацийн хөрөнгөөр 120 айл, “Арвайхээр Хурд” ХХК-ны 54 айл, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэсийн 56 айл, Иргэн Нэргүйгийн 45 айл, Улсын бүртгэлийн хэлтсийн 17 айл, Иргэн М.Батболдын 20 айл нийт 312 айлын орон сууц ашиглалтанд орлоо.</p> <p>Баян-өлгий аймаг: 2015 онд аймгийн төвд иргэн Т.Ербалагийн 8 айлын нийтийн орон сууцны барилга, “Автотранс”ХХК-ны 40 айлын нийтийн орон сууцны барилга, Зэвсэгт хүчний 340-р ангийн эхний ээлжийн 40 айлын нийтийн орон сууцны барилга, “Эрчим”ХХК-ны 48 айлын ажилчидын нийтийн орон сууцны барилга, “Агайын” ХХК-ны үйлчилгээний төвтэй 2-р ээлжийн 25 айлын нийтийн орон сууцны барилга, “Нур-Данеско”ХХК-ны 2-р ээлжийн 20 айлын нийтийн орон сууцны барилга нийт 181 айлын нийтийн орон сууцны барилга ашиглалтанд орсон. Аймгийн төвд 900 айлын болон “Эрчим” ХХК-ны “Хутты-Мекен” 648 айлын нийтийн орон сууцны цогц хороололуудын гадна инженер шугам сүлжээний ажлын зураг төсвийг “ДНТ” ХХК 49 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Мөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө нь Өлгий хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдсэн. 8 хувийн урт хугацааны орон сууцны зээл хэрэгжнээс хойш аймгийн хэмжээнд нийт 295, 2015 онд аймгийн хэмжээнд 65 иргэн 8 хувийн урт хугацааны орон сууцны зээлд хамрагдсан байна.</p> <p>Баянхонгор аймаг: “Хонгор-1000” орон сууцны хорооллын 144 айлын 4 барилга ашиглалтад орсон. 2012-2015 онд нийт 1224 айлын орон сууц ашиглалтад ороод байна. 2015 онд “Төрийн Орон сууцны корпораци” 3 байршилд 120 айлын орон сууц барихаар зураг төсөв нь хийгдэж байна.</p> <p>Булган аймаг: 2014 онд боловсруулсан зураг төслийн дагуу хийгдэж буй ажлууд хөрөнгө оруулалтын ажил удаашралтай байна. “6Д” хорооллын гадна инженерийн шугам сүлжээний горимын тооцоо хийлгэж, барилгын дулаан алдагдлыг багасгах арга хэмжээний тооцоо, зөвлөмж гаргах ажил хийгдэж байна.</p> <p>Говь-Алтай аймаг: Монгол Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн “1000 айлын орон сууц” төслийн хүрээнд “Солонго” хорооллын эхний ээлжийн тус бүр 60 айлын 2 блок орон сууцны барилгын шав тавигдсан бөгөөд зураг төслийг “Гандирс орд” ХХК хийж, гүйцэтгэгчээр “Хөх бүрдний эх” ХХК шалгаран ажил эхлээд байна.</p> <p>Говьсүмбэр аймаг: 2015 онд Шивээговь суманд 30 айлын орон сууцны барилгыг “Тэмүүн холдинг”ХХК, “Шивээ овоо”ХХК-ын ажилчдын 60 айлын орон сууцны барилгыг “Оргил таур”ХХК тус тус засварлан ашиглалтад хүлээлгэн өгсөн. Цаг уур орчны шинжилгээний газрын 12 айлын ажилчдын орон сууцны барилга ажил ашиглалтад хүлээлгэн өгөх шатандаа байна.</p> <p>Дархан-Уул: “1000 айлын орон сууц” төслийн хүрээнд:</p>
---	---

	<p>2013 онд 35.3 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй 923 айл</p> <p>2014 онд 36.2 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй 826 айл</p> <p>2015 онд 32.6 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй 692 айл</p> <p>2013-2015 онд нийт 104.1 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй 2441 айлын орон сууц ашиглалтанд орж “Минж проперти”ХХК Дархан сумын 14-р баг, 2-р хороололд 470 айлын “Парк таун” хотхон, “Мираклленд”ХХК-ийн Дархан сумын 12-р баг, 14-р хороололд “Хүслийн хотхон” , 29-р хороололд “Оргил” хотхон, Дархан сумын 13-р баг 10-р хороололд 144 айлын “Альфа таун” хотхон, Дархан сумын 8-р баг 17-р хороололд “Будда таун” хотхон тус тус бий болж үргэлжлэн баригдаж байна.</p> <p>Дорнод аймаг: 1800 айлын нийтийн болон амины орон сууц, сургууль, цэцэрлэг, урлаг соёлын төв, спорт амралтын төв, гал унтраах анги байхаар иж бүрнээр нь төлөвлөсөн хорооллын гадна инженерийн шугамын өргөтгөлийн зураг төсвийг “ДОЗТ” БГБХН гүйцэтгэж баталгаажуулан БХБЯ-нд хүлээлгэн өгсөн. “100000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Чойбалсан хотод 2015 онд 364 айлын 8 орон сууцны барилга ашиглалтад орсон ба 135 айлын 3 барилга ашиглалтад орохоор хүлээгдэж байна. Мөн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 2-г барьж ашиглалтад оруулаад байна.</p> <p>Дорноговь аймаг: Сайншанд сумын 3-р багийн нутаг дэвсгэрт Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлтэй хуучин ашиглалтын шаардлага хангахгүй болсон авто гараашийн зориулалттай газарт дахин төлөвлөлт хийж, АЗДТГ-ын захиалгатай “Берилл билд” ХХК-ний /2х30=60/ айлын орон сууцыг 2200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж 2015.08.07-ны өдөр байнгын ашиглалтад оруулан төрийн албан хаагчдыг ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлээд байна.</p> <p>2015 онд аймгийн хэмжээнд 499 айлын 12 орон сууцны барилга шинээр ашиглалтад орсон. Үүнд:Сайншанд суманд 383 айлын 9 орон сууцны барилга, Замын-Үүд суманд 76 айлын 2 орон сууцны барилга, Айраг суманд 40 айлын 1 орон сууцны барилга.</p> <p>Уг ашиглалтад шинээр орсон орон сууцнаас ЭМШУТ, Цагдаагийн газар, ОБХ, Цэцэрлэг, сумдын ЗДТГ-ын нийт 52 албан хаагчид хамрагдсан байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” төслийн хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт “Шинэ Сайншанд” суурьшлын бүсийг байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>“Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн MON-GO204 төсөл”-ийн хүрээнд “Шинэ Сайншанд орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г 11.5 га газрыг хамруулан боловсруулсан.</p> <p>Мөн төслийн хүрээнд 2014 онд Шинэ Сайншанд хороололд 12 км цэвэр, бохир усны шугам сүлжээ,</p>
--	---

	<p>2.7 км дулааны магистрал шугамын өргөтгөл шинэчлэлт, 2015 онд 8.4 Мв дулааны станц, 2 км хатуу хучилттай автозам баригдаж ашиглалтад орсон.</p> <p>2014 онд 120 айлын орон сууцны барилга барих 0.6 га газрыг Төрийн орон сууц корпорацид олгосон. Аймгийн хэмжээнд 2012-2015 онуудад 2200 айлын орон сууц ашиглалтад орсон. 2015 онд 499 айлын 12 орон сууц ашиглалтад орсон байна. Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт баригдсан “Эвийн гэрээ” ХХК-ний гүйцэтгэсэн “Нарлаг шанд” хорооллын 60 айлын орон сууцны барилгын зоорийн давхарт 1-2 өрөө 12 айлын орон сууцыг бага дунд орлоготой иргэдэд түрээслүүлэн ашиглуулж байна.</p> <p>“Амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн зүгээс сумдын газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөнд Сайншанд суманд амины орон сууцны жишиг хорооллын зориулалтаар 350 иргэнд 65.3 га газар, Айраг суманд амины орон сууцны зориулалтаар 0.14 га, Замын-Үүд суманд канад технологийн амины орон сууцны хорооллын зориулалтаар 7.7 га газрыг олгохоор төлөвлөгдөж газар олголтыг зохион байгуулж байна. Түүнчлэн Сайншанд сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт иргэн С.Отгонбаатар нь өмчлөлийн газартаа 64 м2 талбай бүхий ижил загварын 10 амины орон сууцыг барьж эхний ээлжийн барилгууд ашиглалтанд оруулаад байна.</p> <p>Дундговь аймаг: 2015 онд Сайнцагаан сумын 7-р багт “Жигүүр оргил” ХХК-ний захиалгаар баригдсан 50 айлын орон сууцны барилгаас “Орон нутгийн хөгжлийн сан”-ын 300 сая төгрөгөөр 54м² талбай бүхий 6 айлын орон сууцыг худалдан авч орон нутгийн хөрөнгөд бүртгэж ажилласан. 2015 онд Урлаг-спорт заал, дадлагын байрны барилга, гадна тохжилт, дулаан цэвэр усан хангамж 4,0 тэрбум, 200 ортой дотуур байрны барилга 2,28 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга, байгууламж ашиглалтанд орсон.</p> <p>Завхан аймаг: Инженерийн хийцтэй 195 айлын орон сууц ашиглалтад орсон. 2016 онд 89 айлын орон сууц ашиглалтад орохоор хүлээгдэж байна.</p> <p>Орхон аймаг: Тайлант жилийн хугацаанд орон сууцны 28 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 2015 онд 539 айлын орон сууц борлогдож 373 айлын орон сууц нэг метр.кв талбай нь 1 350 000 - 2 700 000 төгрөгөөр борлогдохоор хүлээгдэж байгаа болно. Орон сууцны нэг метр.кв талбайн үнэ дунджаар 1687000 төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад хэвийн өөрчлөлтгүй байгаа юм. 2016 онд 1398 айлын орон сууцны барилга ашиглалтад орох төлөвлөгөөтэй барилга угсралтын ажил хийгдэж байна.</p> <p>Өвөрхангай аймаг: “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” хөтөлбөр амжилттай хэрэгжиж 1136 айлын 42 орон сууц ашиглалтанд ороод байна. 2015 оны хэмжээнд 315 айлын 7 орон сууц ашиглалтанд орсон байна. 2016 онд ашиглалтад орох 48 айлын 3 орон сууц 10-85%-ийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Мөн шинэ төвд нийтийн орон сууцны барилга</p>
--	--

	<p>баруулах 9 компани, бусад багт 13 газарт нийт 5,0 га газар олгоод байна. Арвайхээр сумын 36 айлын 2, 12 айлын 3 орон сууц буюу 1970 оноос өмнө баригдсан нийт 144 айлын сууцыг сууц өмчлөгчдийн хүсэлтийн дагуу “Газар хөдлөлийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар БД 31-103-00*-ийн дагуу Хуучин барилгыг газар хөдлөлтийн тэсвэрлэлтээр нь үнэлж, газар хөдлөлтөд тэсвэргүйг тодорхойлон дахин төлөвлөлтөд оруулах талаар аймгийн хөтөлбөр төлөвлөгөөнд тусгуулан судалгааны ажил хийгдэж эхэлсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн “Цэвэр усны холболт, орон сууцны нөхцөл сайжруулах жижиг зээл олгох” төслөөр аймгийн хэмжээнд 722.6 мянган доллар буюу 1404,2 сая төгрөгийн эх үүсвэр хуваарилагдсаныг Капитал, Төрийн банкаар дамжуулан зээл олгож 97 өрхөд 1200,4 сая төгрөгийн зээл олгоод байна. Үүнд: - инженерийн шугам сүлжээнд холбогдох 5 өрхөд 43,3 сая төгрөг, амины орон сууц шинээр барих 44 өрхөд 657,8 сая төгрөг, мөнгөн хуримтлалын 96 айлын бүлийн 4 бүлд 60 сая төгрөг, орон байрны нөхцөл сайжруулах 48 өрхөд 439,3 сая төгрөг тус тус олгосон байна.</p> <p>Өмнөговь аймаг: Орон сууцны үнийг иргэдийн худалдан авах чадвартай уялдуулан тогтвортой байлгах зорилгоор “Орон сууцны төсөл”-ийн сонгон шалгаруулалтыг явуулж 2013-2014 онуудад 8 ААН-үүдэд 10,3 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгоод байна. Дээрх дэмжлэгт 7 ААН хамрагдсанаас одоогийн байдлаар “Бандиа”ХХК 138 айл, “Баян-авзага” ХХК 50 айл, “Самосон” ХХК 50 айлын орон сууцны барилгыг тус тус барьж байгаа боловч ажил нь удаашралтай, гэрээний нөхцөлөө хангаж ажиллахгүй байна. “Бандиа” ХХК-ийн барьж буй “138 айлын амины орон сууцны “Баянбулаг хороолол”-ын эхний ээлжийн 2 айлын 22 орон сууцыг 2015 оны 11-р сард ашиглалтанд оруулсан. Үүнээс 2 айлын 13 орон сууцны 1 сууцны талбай нь 80 м2, 9 орон сууцны 1 сууцны талбай нь 55м2 болно. Мөн энэ 2015 онд 50м2 талбай бүхий 6 орон сууцны, 120 м2 талбай бүхий 4 орон сууцны суурийг цутгаж, угсралтын ажлыг гүйцэтгээд байна. Мөн Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсэд “Сайн шал” ХХК амины 29 айлын орон сууц барьж байна. Барилга угсралтын явц 80 хувьтай байгаа бөгөөд дээрх орон сууцуудыг ашиглалтад оруулсанаар нийт төслийн 79,3 хувьд хүрэх юм. 2015 оны хувийн хөрөнгө оруулалтаар “Мэнд констракшн” ХХК-ийн 40 айлын орон сууц, “Минами говь” ХХК-ний 50 айлын 2 орон сууцны барилгууд баригдаж ашиглалтанд ороод байна. Мөн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, орон нутгийн сангаас дэмжлэг авсан “Эл Эс Би”ХХК-ний 35 айлын орон сууц, “Хүннүгийн говь”ХХК-ний 70 айл орон сууцны барилга, “Гал мөнх” ХХК-ий 63 айлын орон сууцны барилгууд энэ онд ашиглалтанд орсон. “Гал мөнх”ХХК-ий 77 айлын орон сууцны гүйцэтгэл 50%, “Тод бат андууд”ХХК-ний 42 айлын орон сууцны барилгын ажил 40%- ийн гүйцэтгэлтэйгээр тус тус баригдаж байна. 2015 онд</p>
--	---

энэхүү төслийн хүрээнд шалгарсан “Хүннүгийн говь” ХХК-д 1,55 тэрбум төгрөг, “Тод бат андууд” ХХК-д 1,0 тэрбум төгрөг, нийт 2,55 тэрбум төгрөгний дэмжлэгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгоод байна.

Сүхбаатар аймаг: Баруун-Урт хот 1 дүгээр багт бага дунд орлоготой, залуу гэр бүлд зориулсан 57, “Green town” 360 айлын орон сууцны хороололд 77, “Цайрт минерал” ХХК ажилчдын 72 айлын, Эрдэнэцагаан сум 20, Баяндэлгэр суманд 24, Одкон хотхонд 36, Залуус хотхонд 16 айлын орон сууцны барилгууд баригдаж ашиглалтанд орж 2014 онд аймгийн хэмжээнд нийт 264 айлын орон сууцны барилга ашиглалтад орсон. 2015 онд аймгийн Цагдаагийн хэлтсийн 20 айлын орон сууцны барилга ашиглалтад ороод байна.

Сэлэнгэ аймаг: Аймгийн төвд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар буюу “Видү” ХХК нь 56 айлын 10 давхар барилгыг 2015 оны 1 дүгээр улиралд барьж ашиглалтад оруулсан бөгөөд аймаг орон нутгийн зүгээс хөнгөлөлттэй зээл олгосон. Мөн “ТОСК”-ын хөрөнгө оруулалтаар Мандал суманд 126 айлын орон сууцны барилгыг 2015 оны 11 дүгээр сард байнгын ашиглалтанд хүлээн авсан. Дээрхи ажлын хүрээнд хувийн хэвшлийн “Гурван Тулгат Цамхаг” ХХК –нь канад технологиор таун хаус, амины орон сууцны хаус хороолол барьж эхлээд байна. Эхний ээлжийн 4 айлын 1ш таун хаус, 2ш амины 2 давхар хаус баригдаад байна. “Сэлэнгэ-25” орон сууцны төсөл Аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна. Одоогийн байдлаар Баянгол суманд 30 айлын 1 ш, Цагааннуур, Шаамар, Ерөө зэрэг 3 суманд тус бүр 1ш 25 айлын орон сууц баригдаж байна. Гүйцэтгэл 80%-тай 2016 оны 1-р улиралд ашиглалтанд орохоор хүлээгдэж байна. 2016 онд Сүхбаатар суманд цагдаа, ШШГГ-ын ажилчдад зориулсан 30 айлын 2ш орон сууц, Баянгол, Цагааннуур, Баруунбүрэн, Хушаат, Жавхлант, Номгон сумдад тус бүр 1ш 30 айлын орон сууц барихаар төлөвлөсөн.

Төв аймаг: 2009-2013 онд Зуунмод хотод бага, дунд орлоготой өрхийн 20 айлын орон сууц, шүүхийн ажилчдын 32 айлын сууц, төрийн албан хаагчдын 38 айлын орон сууц, хуульчдын хотхоны 15 айлын сууц, цагдаагийн 25 айлын 2 орон сууц, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 8 айлын орон сууц, татварын ажилтны 15 айлын орон сууц, эрчим хүчний ажилтны 30 айлын 1 сууц, 25 айлын 1 сууц, “Өгөөж Сүмбэр” компанийн барьсан 25 айл, Энхтайван багийн 20 айлын 40 айлын сууц, бага дунд орлоготой өрхийн 30 айлын орон сууц, шүүгч нарын 16 айлын орон сууц нийт 364 айлын 14 сууц ашиглалтанд ороод байна.

Мөн хөдөө сумдад Баяндэлгэр суманд 6 айл, Баян суманд 4 айл, Баянжаргалан суманд 2 айл, Баян-Өнжүүл суманд 12 айлын орон сууц ашиглалтанд орж, төсвөөс 155,0 сая төгрөг зарцуулаад байна.

2015 онд аймгийн ОБГ-ын 12 айлын орон сууц, Угтаалцайдам суманд 16 айлын орон сууц, Зуунмод суманд 1000 айлын орон сууцны хорооллын эхний ээлжийн 96 айлын орон сууцнууд ашиглалтанд орж одоо нийт 158 айлын орон сууцны барилгын ажил

		<p>хийгдэж байна.</p> <p>Увс аймаг: “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” төслийн хүрээнд Увс аймгийн Улаангом сумын 3-р багийн нутаг дэвсгэрт “Галдан бошигт” орон сууцны хорооллын бүс төлөвлөсөн. 2015 онд нийт 312 айлын орон сууцны барилга ашиглалтад орсон байна. “Мөнхийн Ундраа” ХХК Галдан бошигт 350 айлын орон сууцны эхний ээлжийн 105 айлын орон сууц, “Аянжин” ХХК 16 айл, “Мөнгөн хээ” ХХК-ийн 24 айл, “Өгөөмөр өгөөж” ХХК-ийн 12 айл, “Сантех-Увс” ХХК-ийн 20 айл, “Цагаан хөшөө трейд” ХХК 50 айл, “Ундарга констракшн” ХХК-ийн 16 айл, “Ундрах бүтээмж” ХХК-ийн 24 айл, “Мегамакс групп” ХХК-ийн 45 айл, “Ундарга констракшн” ХХК-ийн 16 айлын орон сууц ашиглалтад орсон байна.</p> <p>Ховд аймаг: “Аймаг бүрт 1000 айлын орон сууц”-ны хорооллын газрын асуудлыг шийдэж Ховд хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Эхний ээлжинд 480 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээний зураг төсвийг боловсруулж, БУА-ыг гүйцэтгэн, 2015.12.06-нд улсын комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээн авсан. Ховд аймагт 2015 онд 640 айлын орон сууц барилгын ажил эхэлсэнээс 488 айлын орон сууц ашиглалтад орж 164 айлын орон сууцны барилга угсралтын ажил үргэлжлэн хийгдэж байна. Ховд аймагт 2015 оны эцсийн байдлаар 2297 айлын 97 орон сууцны барилга ашиглагдаж байна. Ховд аймгийн орон сууцанд оршин суугчдын 80% нь 8%-ийн хүүтэй, урт хугацааны ипотекийн зээлд хамрагдсан. 2014 онд орон сууцны 1 мкв талбайн үнэ дунджаар 1.1 сая төгрөгийн үнэтэй байсан бол 2015 онд орон сууцны барилгын нийлүүлэлт өссөнөөр 1 мкв талбайн үнэ дунджаар 1,02 сая төгрөг болж буурсан байна.</p> <p>Хөвсгөл аймаг: 2008-2015 онд Мөрөн суманд 250 айлын орон сууцыг ашиглалтанд оруулж, “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд “Шинэ Мөрөн”, “Зүүн Мөрөн” орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, “Шинэ Мөрөн” 550 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлсэн. Эдэлбэр газартай амины орон сууцны зориулалтаар Мөрөн сумын 7-р багт 30 айлд газар олгосон бөгөөд инженерийн шугам сүлжээний ажлын хөрөнгө дутагдалтай байгаагаас ажил удаашралтай байна. Мөрөн сумын 10-р багт эдэлбэр газартай нэг маягийн орон сууцтай хаус хорооллыг бий болгохоор төлөвлөн зураг төслийн шатанд байна. Мөн сумын иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг бий болгох үүднээс орон сууцжуулах ажил эхлэж Их-Уул суманд 25 айлын орон сууцны барилга баригдаж дуусах шатандаа байна.</p>
4.4.4. Ажлын байр нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих зорилтын хүрээнд		
18	4.4.4.1. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд богино хугацааны сургалтад хамруулан ажлын байраар хангах	<p>2014 он:</p> <p>ХБНГУ-ын Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт барилгын мэргэжилтэй ажилчдыг давтан сургах чиглэлээр хүсэлт тавьж 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр 6 удаагийн сургалтыг ХБНГУ-д зохион байгуулж 85 ажилтан хамруулав. Энэхүү сургалтыг Монголын барилгачдын холбоо зохион байгуулав. Мөн</p>

	<p>инженер техникийн ажилтнуудыг 2015-2016 онуудад давтан сургах чиглэлээр GIZ-тай Санамж бичиг байгуулахаар ярилцаж тохироод байна.</p> <p>Барилгын салбарын үйлдвэрлэлийн дадлагажуулагч багшийн сургалтыг GIZ-аас санхүүжүүлэн Барилгын хөгжлийн төв, Монголын барилгачдын холбоон дээр анх удаа зохион байгуулж нийтдээ 40 инженер техникийн ажилтан хамрагдав.</p> <p>БНСУ-ын Хөдөлмөрийн яамны харьяа Аж үйлдвэр, хүний нөөцийн хөгжлийн агентлаг, “Далайн салхи” нийгэмлэгтэй байгуулсан гэрээний хүрээнд БНСУ-д нийт 8 удаагийн сургалт зохион байгуулж барилгын салбарын 180 ажилтанг хамруулснаар энэ хүрээнд суралцагчийн тоо 500-д хүрэв.</p> <p>Мөн дээрх гэрээний хүрээнд 2014 оны 3 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод “Монгол-Солонгосын барилгын салбарын хөрөнгө оруулалт, шинэ техник, технологи” сургалтад суурилсан бизнес форумыг амжилттай зохион байгуулав.</p> <p>2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөрийн шугамаар хийгдсэн нийт ажилд 3386 шинэ ажлын байр гарсан бөгөөд үүний 2160 нь байнгын 1226 нь түр ажлын байр байсан. 2014 онд нийтдээ 89 барилгын материалын үйлдвэр ашиглалтад орсон бөгөөд эдгээрт нийтдээ 1238 ажлын байр шинээр бий болсон. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 78 ажилд нийтдээ 948 хүн шинээр ажлын байраар хангагдсан. Мөн улсын хэмжээгээр 24744 орон сууцны барилга барьж ашиглалтад оруулсан байна.</p> <p>2014-2015 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид барилгын мэргэжлээр, баклаврын зэргээр 18 мэргэжлээр нийтдээ 7692 хүн суралцаж байгаа бөгөөд үүний 1856 нь эмэгтэй суралцагч байна.</p> <p>2014-2015 оны хичээлийн жилд барилгын салбарын 18 мэргэжлээр нийтдээ МСҮТ-д 12037 хүн суралцаж байгаа бөгөөд үүнээс 5104 нь төгсөх ангид суралцаж байна.</p> <p>2014 оны байдлаар 4543 аж ахуйн нэгж барилгын салбарын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ажиллаж байгаа бөгөөд 3833 нь барилга угсралт, 470 нь зураг төсөл, 140 нь өргөх байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нийтдээ 62695 хүн ажиллаж байгаа бөгөөд 19579 нь инженер техникийн ажилтан, 43116 нь мэргэжилтэй ажилчин байна. 2010-2016 онд нийтдээ барилгын материалын үйлдвэрийн салбарт 8761 ажлын байр бий болно.</p> <p>Сумын төвийн инженерийн шугам сүлжээний ашиглалт хариуцсан ажилтан бэлтгэх сургалтыг НҮБ, АХБ болон ШУТИС-тай хамтран үе шаттайгаар зохион байгуулсан. Анхан шатны сургалтыг 2014.05.19-нөөс 30-ныг хүртэлх хугацаанд, давтан сургалтыг 2014.09.15-наас 26-ныг дуусталх хугацаанд зохион байгуулсан. Сургалтад 18 аймгийн 31 сумын 43 хүн хамрагдсан.</p> <p>2015 он:</p> <p>Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлж буй “Уул</p>
--	--

		<p>уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн хүрээнд барилга, хот байгуулалтын салбарт 55000\$-ын санхүүжилт бүхий 4 сургалтыг зохион байгуулж 180 хүн хамруулав.</p> <p>Барилга, хот байгуулалтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон нийт ажлын байрны судалгааг гаргасан бөгөөд одоогоор барилга угсралтын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 4801 аж ахуйн нэгжид 78660, хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй 547 аж ахуйн нэгжид 1500, өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй 167 аж ахуйн нэгжид 1000, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэн явуулдаг 800 аж ахуйн нэгжид 14000, геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулдаг 188 аж ахуйн нэгжид 335, газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг 51 аж ахуйн нэгжид 200 хүн, нийтдээ 5582 аж ахуйн нэгжид 95695 хүн ажиллаж байна.</p> <p>Испанийн Вант Улс, Барилга, хот байгуулалтын яамны хамтын ажиллагааны дагуу Монгол Улсад шинээр байгуулах "Барилгын мэргэжлийн сургалтын төв"-ийн барилга, байгууламжийг барих ажлын төлөвлөгөөний төслийг, 2015 оны сургалтын саналын хамт боловсруулж хүргүүлэв.</p> <p>Булган аймаг: Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2014 онд цахилгаан ба хийн гагнуурчин 25, сантехник 18, барилгын өргөн мэргэжлээр 23 нийт мэргэжилтэй ажилтаныг төгсгөөд байна.</p> <p>Говьсүмбэр аймаг: 2015 онд жижиг дунд бизнес эрхлэгчид хамтран "Чойр кашмер"ХХК үйлдвэрийн байрыг бий болгож барилгын ажлыг "Чойр хайрхан"ХХК гүйцэтгүүлэн ашиглалтад оруулсан.</p>
19	4.4.4.2. бүтээн байгуулалтын ажилд шаардагдах инженер техникийн ажилтан бэлтгэх	<p>2014 он:</p> <p>ШУТИС-ийн БИАС дээр иргэний ба үйлдвэрлэлийн барилга инженер, ус хангамж, ариутгах татуургын инженер, барилгын материал үйлдвэрлэлийн технологи инженер мэргэжлээр шинээр эчнээ анги нээлгэх хүсэлтийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд тавьж улмаар 2014-2015 оны хичээлийн жилээс Иргэний ба үйлдвэрлэлийн барилгын инженерийн эчнээ анги нээв.</p> <p>"Салбарын инженер техникийн ажилтны мэргэшлийн зэрэг горилох, сунгах, ахиулах сургалт"-ыг зохион байгуулах ажлын хүрээнд: нийт 33 удаагийн сургалт зохион байгуулж 1142 мэргэжилтнийг мэргэшүүлэв.</p> <p>Үүнд: Мэргэшлийн зэрэг сунгах, ахиулах 12 удаагийн сургалтад 380, мэргэшлийн зэрэг шинээр горилох 21 удаагийн сургалтад 762 мэргэжилтэн хамрагдсан байна. Урт, богино хугацааны чадавхижуулах сургалт 26 удаа зохион байгуулж нийт 652 инженер, техникийн ажилтныг сургалтад хамруулсан байна.</p> <p>Бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтын байгууллагад шинжээчээр ажиллах барилгын салбарын мэргэжилтнүүдэд зориулсан төлөвлөгөөт бус сургалтыг зохион байгуулах саналыг Стандарт, хэмжил зүйн газарт тавьж хэрэгжүүлэв.</p> <p>2015 он:</p>

		<p>2014-2015 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид барилгын 18 мэргэжлээр нийтдээ 7692, магистрт 251, докторт 47 хүн суралцаж байна.</p> <p>УИХ-ын дарга З.Энхболдын Япон Улсад хийх айлчлалтай холбогдуулан барилга, хот байгуулалтын салбарын мэргэжилтнүүдийг богино хугацаагаар мэргэшүүлэх сургалтын саналыг боловсруулсан. Барилгын салбарын ажилтнуудыг Бүгд Найрамдах Беларусь Улсад сургах мэргэжлийн чиглэл, суралцагчдын тоог гаргаж хүргүүлэв.</p> <p>Бүгд Найрамдах Унгар Улсад салбарын норм, норматив боловсруулах чиглэлээр төрийн байгууллагад ажиллаж байгаа 5 ажилтны мэргэжлийг дээшлүүлэхтэй холбогдуулан сургалтын хөтөлбөрт нэмж оруулах холбогдох саналыг өгөв.</p> <p>Япон улсын Хирошима, Цукубагийн их сургуулийн багш нартай санал, мэдээлэл солилцох уулзалтыг 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулав.</p> <p>Австралийн тэтгэлэгүүд хөтөлбөрийн Дэд бүтэц, шинжлэх ухаан, мэдээлэл харилцааны технологийн сэдэвчлэн зөвлөх багийн уулзалтад оролцож, салбарын мэдээлэл хийсэн.</p> <p>Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол Улсад хэрэгжиж байгаа “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 2015 оны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй, шаардлага хангасан салбарын ажилтнуудын нэрсийг 4/2682 дугаартай албан бичгээр 2015 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүргүүлэв. Мөн хөтөлбөрт нэрээ дэвшүүлсэн салбарын 19 ажилтанд мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг JICE JDS Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 15:00 цагаас зохион байгуулав.</p>
20	4.4.4.3. Шинээр баригдах орон сууцны хорооллыг жижиг, дунд бизнес эрхлэх ажлын байрны хамт цогцоор нь барих	<p>Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршилд шинээр баригдах орон сууцны хорооллын жижиг, дунд бизнес эрхлэх ажлын байрны хамт цогцоор барих бодлогыг баримтлан ажиллаж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч болон Нийслэлийн Хөдөлмөрийн газартай хамтран хөдөлгөөнт бирж ажиллуулж одоогоор дахин төлөвлөлтийн байршилд нийт 1500 ажлын байр бий болсон бөгөөд цаашид жилдээ 15000 орчим ажлын байр шинээр бий болох боломжтой юм.</p>
4.4.7. Үйлдвэржилтийг дэмжих зорилтын хүрээнд		
21	4.4.7.1. Аймаг, нийслэл, бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, барилгын материалын үйлдвэр, үйлдвэрлэл, технологийн парк, материалын сорилт шинжилгээний иж бүрэн лаборатори байгуулах	<p>Дотоодын хэрэгцээг бүрэн хангах барилгын материалын импортын гаалийн тарифыг нэмж үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах санал боловсруулан Аж үйлдвэрийн яаманд хүргүүлж, “Импортын гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2015.07.09-ны өдрийн 74 дүгээр тогтоол батлагдсан. Уг тогтоолд барилгын материалын 7 бүлэгт өөрчлөлт оруулахаар тусгуулсан бөгөөд Засгийн газрын 2015.08.17-ны өдрийн 332 дугаар тогтоолоор импорын татварыг нэмэгдүүлэх барааны жагсаалт батлагдсан.</p> <p>2015 онд шинэ технологи нэврүүлэх, барилгын материалын чанарыг сайжруулах, санхүүгийн</p>

	<p>асуудлыг шийдвэрлэх, дотоодын үйлдвэрлэлийг импортын хамаарлаас гаргах чиглэлээр 70 гаруй албан бичгийг холбогдох аж ахуйн нэгж, яам, банкуудад хүргүүлж ажилласан.</p> <p>Эрэл компанийн БҮК-1 төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2013 оны 180, 2014 оны 113, 2015 оны 319 дугаар тогтоолууд батлагдсаны дагуу Хөгжлийн банкнаас санхүүжилт хийн, мөн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татварыг 2 жилийн хугацаатай хойшлуулах талаар Засгийн газрын 2014 оны 284 тоот тогтоол гаргуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг импортоор оруулж ирэн угсралтын ажил хийгдэж байна.</p> <p>Дорноговь аймгийн шохойн чулууны ордод түшиглэн цементийн үйлдвэр байгуулахаар ажиллаж буй "МАК" ХХК, "Монполимет" ХХК-иудын хэрэгжүүлж буй төслийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас шийдвэрлэж, "Монполимет" ХХК-ийн 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэрийг 2015 онд ашиглалтад оруулсан. 2015 онд 141 аж ахуйн нэгж барилгын материалын тусгай зөвшөөрөл шинээр болон сунгуулан ажиллаж байна.</p> <p>Архангай аймаг: Архангай аймгийн Эрдэнэмандал суманд 6 тэрбум төгрөгөөр баригдах "Үйлдвэр технологийн парк"-ын угсралтын ажил 2015 онд эхлэсэн. 2016 онд гадна шугам сүлжээний ажилд 2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн.</p> <p>Баянхонгор аймаг: 2015 оны байдлаар барилгын материалын "Баянтал"ХХК нь "Хүрмэн блок", "Явган замын хатван"-ын үйлдвэрлэлээр тохирлын гэрчилгээ, "Тэнүүн хонгор" ХХК 2015 оны 05-р сарын 21-нд 3.7.3 заалтаар тусгай зөвшөөрөл аваад байна. Барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй компаниудын үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний мэдээг сар болгон авч нэгтгээд байна. "Хаш гоёо"-1500м³ бетон зуурмаг, "Жишиг бетон"-8000м³ бетон зуурмаг, "Их богд" тоосгоны үйлдвэр 325000 тоосго үйлдвэрлэснээс 175000-ыг борлуулсан байна. 2014.06.21-ээс эхлэн өөрийн лабораторид байгаа тоног төхөөрөмжийг ашиглан бетоны лаборатори, бетон дүүргэгч материалын лаборатори, керамик материалын лабораторийн шинжилгээ хийж байна. "Баянтал" ХХК-ны ВLС, Тi, "Өлзийт хиймор өөдөө" ХХК-ын SA, CU болон "Баянтал"ХХК нь "Хүрмэн блок", "Явган замын хавтан" үйлдвэрлэх тохирлын гэрчилгээ авах бүтээгдэхүүнд сорилтын хяналт хийгдсэн.</p> <p>Булган аймаг: Барилгын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2013 онд Булган сумын 2 иргэнд 63,5 сая төгрөгийн зээлийг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон байна. Үүний дунд барилгын ханын материалын үйлдвэрлэлийг тус суманд албан ёсоор эрхлэх боломж бүрдсэн. Аймгийн ГХБХБ-ын газрын дэргэд барилгын сорьц шинжилгээний лабораторыг байгуулахаар барилгын зураг төслийн дагуу хөрөнгө оруулалт хүссэн материалыг БХБ-ын яаманд хүргүүлсэн боловч 2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдаагүй бөгөөд тус газрын хуучин конторын байрыг Барилгын материалын туршилтын</p>
--	--

	<p>лаборатори болгохоор зураг төсөв дахин боловсруулж, эхний ээлжинд прессийг суурилуулж, цахилгааны асуудлыг шийдвэрлэсэн болно.</p> <p>Говь-Алтай аймаг: “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн “Үйлдвэржилтийг дэмжих” зорилтын хүрээнд аймгийн төвд баригдах “Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори”-ийн барилгыг орон нутгийн төсөвт суулгаж тус газрын даргын 2015.11.20-ны 420 тоот албан бичгээр аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгасны дагуу тус барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори, албан конторын барилгын хөрөнгө оруулалтын асуудлыг дэмжих тухай хүсэлтийг БХБЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Мөн Говь-Алтай аймагт “Айргийн хад”, “Тулга-Алтай”, “Алтайн гэрэлт өргөө”, “Залуур Алтай” ХХК-ууд тоосгоны үйлдвэрүүд нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ орон нутгийн бүтээн байгуулалт болох Хотын төв зам дагуу өнгөлгөөний тоосгоор ногоон байгууламжийн хайсны ажил, САХ 2 багц болох харуулын байр, Иргэн Ч.Амарсанаагийн 9 айлын орон сууц, Бигэр сумын 100-н хүүхдийн цэцэрлэгийн барилга, “Сумын төвийн шинэчлэл” төслийн уурын зуухны барилга зэрэгт нийлүүлэн ажиллалаа. “Тулга-Алтай” ХХК 2014 онд 400,0 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар цагт 50 м³ бетон зуурмаг үйлдвэр, 1цагт 80 тн хайрга, дайрга бутлан ангилах үйлдвэр “Аксу-Алтай” ХХК 2014 онд 700,0 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар цагт 25 м³ бетон зуурмаг үйлдвэр, 1цагт 40тн хайрга, дайрга бутлан ангилах үйлдвэрүүдийг ашиглалтад оруулан 2015 онд нийтдээ 512м3 бетон зуурмагийг “Төрийн банк”-ны шинэ барилга, 960 суудалтай сургуулийн барилга, нутгийн зөвлөлийн санаачлагатай 34*36 хэмжээтэй агаарын теннисийн талбай, “Аксу-Алтай”ХХК-ны 50 айлын орон сууц, Иргэн Б.Түмэндэмбэрэлийн 50-н айлын орон сууц зэрэг бүтээн байгуулалтанд нийлүүлсэн. Мөн “Дуурсах Алтай”ХХК нь 2014 онд 65 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалтаар хоногт 15 м3 үйлдвэрлэх хүчин чадалтай полистрол хавтангийн үйлдвэр ашиглалтанд оруулан 2015 онд нийтдээ 176,6м3 полистрол хавтан үйлдвэрлэж, “Уран-Охид” ХХК-ны 25-н айлын орон сууцанд, Бигэр сумын 100-н хүүхдийн цэцэрлэгийн барилгуудын гадна хашлагын өрөг угсралтын ажилд нийлүүлэн ажилласан.</p> <p>Говьсүмбэр аймаг: Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторын барилгын зураг төслийг зураг төслийн “Ориентплюс”ХХК хийж гүйцэтгэн БХБЯ-нд хүлээлгэн өгсөн боловч одоогоор хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн байр болон материалын чиглэлийн мэргэжилтэй боловсон хүчний дутагдалтай байдлаас лабораторийн үйл ажиллагааг эхлүүлээгүй байна. Сүмбэр суманд “Осо</p>
--	--

констракшн"ХХК нь хуванцар рамтай цонх, хаалганы үйлдвэрлэл эрхэлж орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

Дархан-Уул: Аж үйлдвэрийн яам, "Дархан" үйлдвэрлэл Технологийн паркийн Ашиглалтын өмнөх Захиргаа, ШУТИС-ийн судлаачид хамтран "Дархан" Үйлдвэр Технологийн Паркийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын урьдчилсан судалгааг 2008 онд хийж гүйцэтгэсэн.Аймгийн ИТХ-ийн 2011 оны шийдвэрээр "Дархан" Үйлдвэрлэл Технологийн Паркын газрыг 3 бүсэд хуваасан. Үүнд:1-р бүс: Хүнд үйлдвэрийн бүс-870 га, 2-р бүс: Хөнгөн, хүнсний үйлдвэрийн бүс-870 га, 3-р бүс: Сургалт, эрдэм шинжилгээний бүс-193 га.

Дархан-Уул аймгийн 2013-2015 онуудад дараах барилгын материалын үйлдвэрүүд бий болсон. Үүнд: "Си Эм Пи Ай" ХХК-ийн Төмөр бетон конусан шонгийн үйлдвэр, "Сонголон хайрхан" ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэр, "3 эрдэнэ цемент" ХХК-ийн чулуунцар тээрэмдэх шугам бүхий цементийн үйлдвэр, "Дархан минж"ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр, "Чин Удам" ХХК-ийн царууц тоосгоны үйлдвэр, "Дархан трейд" ХХК-ийн хуванцар цонх, хаалганы үйлдвэр, "Идэрхайрхан" ХХК-ийн чулуу бутлан ангилах, "Дархан Эрдэнэбүрэн"ХХК-ийн шохой, магнийн болон гөлтгөнө барьцалдуулагч материалын үйлдвэр /шатаасан шохой/, "Тулгат шийр"ХХК-ийн шохой, магнийн болон гөлтгөнөн барьцалдуулагч материалын үйлдвэр /шатаасан шохой/, "Сутайн үхэр чулуут"ХХК-ийн Шохой, магнийн болон гөлтгөнөн барьцалдуулагч материалын үйлдвэр /шатаасан шохой/, "Болор ган"ХХК-ийн хөнгөн бетон гулдмайн үйлдвэр, "Тэгш хан"ХХК -ийн Керамик тоосгоны үйлдвэр, "Сонголон хайрхан"ХХК-ийн чулуу бутлан ангилах үйлдвэр, нийт 7,7 тэрбум төгрөгний төсөвт өртөг бүхий үйлдвэрүүд байгуулагдлаа.

Дорнод аймаг: Орон нутагт барилгын материалын лабораторийг ажиллуулж эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байгаа ба зарим шаардлагатай тоног төхөөрөмжийг БХБЯ-наас нийлүүлэгдсэн байна. Мөн лабораторийн барилга байгууламжийг бариулахаар Барилгын зураг төслийн институтээр нэг маягын зураг төсөл хийгдсэн. 2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан боловч төсвийн тодотголоор хөрөнгө буцаан татагдсан.

Дорноговь аймаг: Өргөн сумын нутаг дэвсгэрт "Монполимет групп"-ын охин компани болох "Сэнж сант" ХХК нь Сэнжит худгийн шохойн ордыг түшиглэн хоногт 3000 тн чулуунцар буюу 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай орчин үеийн хуурай аргын "Монцемент" үйлдвэрийг байгуулж 2015.08.14-нд нээлтээ хийсэн. Тус үйлдвэр ашиглалтад орсноор Олон улсын ISO, Монгол улсын MNS974-2008 стандартуудыг хангасан OPC 42.5, OPC 52.5, PC 42.5, PC 52.5, PC 62.5 ангиллын порланд цементийг эх орондоо үйлдвэрлэж дотоодын хэрэгцээнд нийлүүлэх боломж бүрдээд байна.

Орхон аймаг: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01 тогтоолоор аймгийн Жижиг, дунд болон өрхийн

	<p>үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих бодлого, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, холбогдох хэлтэс, албадад хүргүүлж, иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна. 2015 оныг “Үйлдвэрлэл бизнесийг дэмжих жил” болгох зорилт дэвшүүлэн ажилласан.</p> <p>2015 онд Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн зээлээс 40 төсөлд 275,3 сая төгрөгийн зээлийг, Жаргалант сум 6 төсөлд 28,5 сая.төгрөгний зээлийг олгов. Аймгийн Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангаас 35 төслийг дэмжин 474,7 сая төгрөгийн зээлийг, АҮЯ-ны ЖДҮХС-аас 10 төсөлд 1250,0 сая төгрөгний зээлийг , ХЭДС-ийн зээлд 73 иргэн, аж ахуйн нэгж хамрагдан 319,3 сая төгрөгийн зээлийг авсан байна.</p> <p>2015 онд нийт 164 аж ахуйн нэгж, иргэн хөнгөлөлттэй зээлд хамрагдан 2347,8 сая.төгрөгний зээл авсан нь өнгөрсөн оноос олгосон зээлийн хэмжээ 340,8 сая.төгрөгөөр нэмэгдсэн байна.</p> <p>190 иргэн аж ахуйн нэгжид 2223,0 сая.төгрөгний зээл олгож 438 ажлын байр шинээр бий болсон 201 ажлын байр хадгалагдсан байна. Төсөл хөтөлбөрийн хүрээнд 45 иргэнд 66,0 сая.төгрөгний зээл олгож 93 ажлын байр бий болсон байна. 2015 онд шинээр 14 үйлдвэрлэл үйлчилгээний газар шинээр бий болсон.</p> <p>2015 онд Аж үйлдвэрийн салбарт 1.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 1.3 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өнгөрсөн оны үеэс үйлдвэрлэлт 11.0 хувиар, борлуулалт 9.5 хувиар буурсан. Өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт боловсруулах аж үйлдвэрийн салбарт 29.6 хувиар, цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 17.7%-иар өсч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 11.3%-иар буурсан. Энэ онд катодын зэс үйлдвэрлэл, төмөр хийц үйлдвэрлэл, “Хээтэй шил” шилэн хийц үйлдвэрлэл, хэвлэх, металл хийц үйлдвэрлэл, лед гэрэл үйлдвэрлэл, бетон зуурмаг үйлдвэрлэл, асфальтон зуурмаг үйлдвэрлэл, гутал үйлдвэрлэл, тавилга үйлдвэрлэл, мөс үйлдвэрлэл, хэрчсэн гурил үйлдвэрлэл, плитаны цавуу, бетон зуурмагийн бэхжүүлэгч, ариун цэврийн цаас үйлдвэрлэл нэмэгдлээ.</p> <p>Өвөрхангай аймаг: Барилгын материал үйлдвэрлэл явуулахаар хүсэлт ирүүлсэн 8 аж ахуйн нэгжид Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар эзэмшүүлснээр нийт 11.25 мянган ширхэг сийрмэг бетон гулдмай, 805 ш хүрмэн гулдмай үйлдвэрлэсэн нь орон нутгийн хэрэгцээт ханын материалын 18 хувийг хангаж байна. Цаашид үйлдвэрлэлийн технологийн горимыг бүрэн тогтворжуулж, бүтээгдэхүүний стандартын шаардлагыг дээшлүүлэн, мөн аймгийн хэмжээнд баригдах барилгын зургийн даалгаварт тусгах замаар орон нутгийн ханын материалын хэрэгцээнд эзлэх хувийг улам нэмэгдүүлэх боломжийг судлаж байна. Бетоны бат бэхийг тодорхойлогч пресс, элс , хайрганы цахилгаан шигшүүр, хатаах шүүгээ зэрэг бетон дүүргэгч материалын лабораторийн 13 нэр төрлийн 10,2 сая.төг-ийн багаж, тоног төхөөрөмжийг</p>
--	--

	<p>суурилуулан ажиллуулж эхлээд байна. Бетоны бат бэх, элс хайрганы бохирдол, дулаалгын хөөсөнцөрийн нягтыг тодорхойлох шинжилгээг 33 объектийн 212 дээжинд хийхэд нийт шинжилгээний 74 хувь нь зураг төсөл, стандартын шаардлагыг хангаж бетон хийцийн чанар сайжирч, дулаан тусгаарлах хөөсөнцөрийн стандартын шаардлагыг хангуулахад ахиц гарч эхэлж байна.</p> <p>Өмнөговь аймаг: Даланзадгад сумын төвд баригдаж буй “Барилгын материал сорил шинжилгээний лаборатори”-ийн барилгын баригдаж байгаа бөгөөд барилга угсралтын ажлын 55 хувийг гүйцэтгээд хөрөнгийн эх үүсвэргүйгээс барилга угсралтын ажлыг зогсоогоод байна.Барилгын материалын үйлдвэрийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Сүхбаатар аймаг: Баруун-Урт суманд “Сэвүүн уудам тал” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар бетон зуурмагийн үйлдвэр байгуулагдаж, “Манал-Овоот” ХХК ханын хөнгөн дүүргэгч блок, “Олон давна” ХХК-ийн жилд 2.0 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай тоосгоны үйлдвэр, “Бага өлгий” ХХК-ийн чулууны карьер, “Дарцагт овоо” ХХК-ийн явган болон авто замын хавтан, өнгөлгөөний тоосго, далангийн эко хавтан, даацын блок зэргийг орон нутагтаа үйлдвэрлэж байна. Туршилтын журмаар үйлдвэрлэж байгаа голдоо нүхтэй элс цементэн блокыг үйлдвэрлэх хувийн хөрөнгө оруулалттай жижиг цехүүд үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Сэлэнгэ аймаг: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7-р баг “Сэлэнгэ баян-Уул”ХХК-ийн байгалийн түгээмэл тархацтай түүхий эд болох элсэн дүүргэгчтэй дуу дулаан тусгаарлагч гулдмайн /полистрол бетон/ үйлдвэр нээгдэж барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрлөө аваад байна. Тус аж ахуйн нэгжид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ тохирлын гэрчилгээ авах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч бэлтгэл ажлыг хангуулан бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээтэй болгоод байна. Эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар сумын “Шилмэл эсгий” ХХК ноосон дулаалгын материалын төслийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Төв аймаг: Аймгийн хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөц, орон нутгийн онцлогт тулгуурлан Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотод үйлдвэр технологийн холимог паркийн техник, эдийн засгийн үндэслэл, мастер төлөвлөгөөг Засгийн газраас томилогдсон Төслийн баг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын Зөвлөлийн хурлаар батлагдсан. ҮТП 3 үе шаттай хэрэгжих бөгөөд 1-р үе шат буюу 2009-2011 төслийн бэлтгэл хангагдана.</p> <p>2-р үе шатанд 2012-2015 онд эхний үйлдвэрүүд баригдана. 3-р үе шатанд 2016-2021 онд үйлдвэрүүд эцэслэн дуусна.</p> <p>Энэ төслийн хүрээнд 6 чиглэлийн 15 үйлдвэр баригдах юм. Эдгээр үйлдвэрүүдийг байгуулахад 30.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай юм.</p>
--	--

		<p>“Аймгийн хөгжлийн сан”-аас эргэлтэнд зориулж 65.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгон дэмжлэг үзүүлээд байна. 2013 онд Эрдэнэсант суманд 2, Баянхангай 2, Архуст суманд 1 блокны цех шинээр байгуулагдсанаар, Алтанбулаг, Эрдэнэсант, Баянхангай, Архуст, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянчандмань, Заамар, Цээл, Дэлгэрхаан, Сүмбэр, Зуунмод сумдад нийт 13 блокны цехтэй болж 2011 онд аймгийн хэмжээнд нийт 109.4, 2012 онд 111,6 тонн, 2013 оны 11-р сарын 30-ны байдлаар 183,8 хөнгөн блок үйлдвэрлэсэн. Алтанбулаг суманд 2 блокны цех байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. 2011-2013 онд нийт 41050 ширхэг блок үйлдвэрлэн сумынхаа хэрэгцээг хангасан. Төв аймгийн Сэргэлэн сумын Цагаан хяр хэмээх газарт БНХАУ-ын “Үндэсний барилгын материалыг үйлдвэрлэгч” компани 500 сая юанын хөрөнгө оруулалттай жилд 1 сая тн-ын цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэр байгуулагдаж байна. 2016 оны 6-р сард ашиглалтанд орно.</p> <p>Хөвсгөл аймаг: Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй барилгын материал үйлдвэрлэлийн 6 аж ахуй нэгж байна. Тоосгоны 3, бетон зуурмаг, эдлэлийн 1, хөнгөн блокны 1, төмөр хийцийн 1 үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. 2014, 2015 оны байдлаар орон нутгийн сум хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн дэмжлэгтэйгээр 41 иргэн блок, вакум цонх, хөнгөн блок, модон эдлэл, тоосго үйлдвэрлэхээр зээлд хамрагдан үйл ажиллагаагаа явуулж байна. 2015 оны байдлаар барилгын материал үйлдвэрлэлийн томоохон үйлдвэр байгуулагдаагүй.</p>
4.4.8. Шилжилт хөдөлгөөнийг сааруулах зорилтын хүрээнд		
22	4.4.8.4. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	<p>“Нийслэлийн нутаг дэвсгэрт газрыг худалдан авах болон нөхөх олговортойгоор эргүүлэн авах, солих журам”-ыг боловсруулан НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 сарын 08-ны өдрийн 126 дугаар тогтоолоор баталсан. Уг журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 23/02 дугаар тогтоолын хавсралт гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагааны журам батлуулан мөрдөн ажиллаж байна.</p>
7	Дүгнэлт /ололт, дутагдал анхаарах асуудлууд/	<p>Төсөл хэрэгжихтэй холбоотой зарим санхүүжилт шийдэгдээгүй байна.</p> <p>Булган аймаг: <u>Ололттой тал:</u> Хөтөлбөрийн хүрээнд сумын төвийн шинэ суурьшил, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн өргөтгөл шинэчлэлтийн ажил нилээдгүй төлөвлөж зураг төслийн ажлыг улсын төсөв, орон нутгийн төсөвт тусгуулсан.</p> <p><u>Дутагдалтай тал:</u> Зураг төслийн ажил бэлэн болсон хэдий ч санхүүжүүлэх эх үүсвэр дутмаг байна.</p> <p><u>Анхаарах асуудал:</u> Барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлын онцлог байдалд тохируулан санхүүжилтийг гүйцэтгэл бичсэн хугацаанд нь олгож байх, захиалагчийн холбогдолтой хууль, дүрэм, журмыг сайн судалж гүйцэтгэгчид шаардлага тавих, гэрээний үүргээ биелүүлэх шаардлагатай байна.</p> <p>Говь-Алтай аймаг: Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын хяналт хангалтгүй байгаа тул хяналтын тогтолцоог</p>

	<p>сайжруулах, аймгийн төвүүдэд баригдах Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн барилгын ажлыг эхлүүлэх, лабораторийн тоног төхөөрөмжийн нэр төрлийг олшруулах шаардлагатай байна.</p> <p>Дархан-Уул: <u>Анхаарах асуудал</u> Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын хяналт хангалтгүй байгаа тул хяналтын тогтолцоог сайжруулах, аймгийн төвүүдэд баригдах Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн барилгын ажлыг эхлүүлэх, лабораторийн тоног төхөөрөмжийн нэр төрлийг олшруулах шаардлагатай байна.</p> <p>Дорнод аймаг: <u>Анхаарах асуудал:</u> Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг урьдчилан шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай байна.</p> <p>Дорноговь аймаг: Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлын явцын хяналт шалгалт хангалтгүй байгаа тул хяналтын тогтолцоог сайжруулах, тухай жилийн хөрөнгө оруулалтын төсөвт тогтмол хөтөлбөрт тодорхой хөрөнгө суулгаж бодитой үр дүнд хүргэх, хяналт тавих шаардлагатай байна.</p> <p>Дундговь аймаг: <u>Ололттой тал:</u> Захиалагч болон гүйцэтгэгч ашиглагч байгууллагууд төсөл хөтөлбөрүүдийн явцад хамтран захиалагчийн хяналт гүйцэтгэх, орон нутгийн цаашдын хөгжлийг хангах боломжийн нэн тэргүүн тавьж ажилласан бөгөөд үүний үр дүнд барилга угсралтын ажлын чанар сайжирсан.</p> <p><u>Дутагдалтай тал:</u> Шинээр ашиглалтад орсон төвлөрсөн инженерийн хангамжийн ашиглалтын үйл ажиллагааг хариуцах байгууллага тодорхойгүй, мэргэжилтэй ажиллах хүч хангалтгүй байна.</p> <p>Өвөрхангай аймаг: <u>Ололттой тал:</u> Засгийн газраас баталсан “Барилгын материалын үйлдвэрлэлийн дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласнаар хувийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар элс, хайрга бутлан ангилах болон түүнийг түшиглэсэн бетон зуурмагийн үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орсон нь бетоны түүхий эд элс, хайрганы болон цутгамал бетон эдлэлийн чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой болж байна.</p> <p>Ус хангамж, цэвэрлэх байгууламжийн нэгдсэн системийг сумдад байгуулсанаар хувийн хөрөнгө оруулалтаар барилгажих ажил эрчимтэй явагдаж стандартын шаардлага хангасан ундны усаар иргэдийг хангаж байна.Цаашид барилга бүрт цэвэр усны нөөцийн сав, бохир усны цооног барих ажилгүй болсноор эдийн засгийн хэмнэлт гарна. Мөн шинээр барилгажих талбайд инженерийн шугам сүлжээг эхлэн тавьсанаар хот төлөвлөлт алдагдахгүй байх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барилга баригдах таатай нөхцөлүүд бүрдэж байна.</p> <p><u>Дутагдалтай тал:</u> 1. Лабораторийг өргөжүүлэх талаар улсын төсөв төлөвлөгөөнд тодорхой хөрөнгийн асуудлыг тусгаж, орон тоо, хүний нөөцийг батлах шаардлагатай байна.</p> <p>2. Зураг төсөв хийхдээ судалгааны ажлыг нарийн</p>
--	--

		<p>сайн хийх, бохир усны цэвэрлэх байгууламжийн хүчин чадлын сонголтыг оновчтой хийх шаардлагатай байна./Зураг төсвийн байгууллагын сонголт томдож цэвэрлэх байгууламжийн ажиллагааны технологийг алдагдуулахад хүрч байна./ Хөдөө сумдад барих ус түгээх байрны тоо, байрлалыг оновчтой сонгохгүй бол ашиглалтын зардал өндөрсөж үргүй зардал гарч байна. Мөн инженерийн шугам сүлжээг угсрахдаа хэсэгчилсэн байдлаар угсралтын ажлыг гүйцэтгэхгүй бол угсрагдсан шугам удаан хугацаанд ашиглагдахгүй элэгдэлд орох, бүрэн бүтэн байдал нь алдагдах нөхцөлүүд үүсч байна.</p> <p>3. Аливаа төслийг хэрэгжүүлэхэд инженер геологийн судалгаа бүрэн хийгдсэн, хэрэгжүүлэх жилийн өмнөх жил нь зураг төсөв бүрэн батлагдсан байх шаардлагатай байна.</p> <p>Өмнөговь аймаг: <u>Ололттой тал:</u> Хөтөлбөрийн зарим зорилт тухайлбал: “100 мянган айлын орон сууц” төслийн хүрээнд орон сууцны фонд, хангамж нэмэгдсэн, иргэдийг орон сууцны урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулсан, гэр хороололд дахин төлөвлөлт хийх ажлыг эхлүүлсэн, аймаг хотуудыг хатуу хучилттай замаар холбосон, аймаг, сумдуудыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбосон.</p> <p><u>Дутагдалтай тал:</u> Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр боловсруулж батлуулах болон шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын ихэнх нь батлагдаагүй, хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс зарим зорилтууд хэрэгжиж үр дүнгээ өгөхгүй байна.</p> <p>Төв аймаг: <u>Анхаарах асуудал:</u> Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардагдах хөрөнгө оруулалтыг урьдчилан тооцох шаардлагатай байна.</p> <p>Хөвсгөл аймаг: Үйлдвэржилтийг дэмжих зорилтын биелэлт хангалтгүй байна. Учир нь эдийн засагт нөлөө үзүүлэхүйц томоохон барилгын материалын үйлдвэрлэл байгуулахад иргэн, аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.</p>
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь аймаг: Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлуудад хийгдэх захиалагчийн техникийн хяналтыг орон нутгийн ГХБХБГазартай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.</p> <p>Өвөрхангай аймаг: Хэрэгжүүлэгчийн зүгээс ажлаа хугацаанд нь гүйцэтгэхээр хэрэглэгчээс гаргаж байгаа ажлын графикийг хугацаанд нь бариулахын тулд ажлын гүйцэтгэлд хурдан хугацаанд баталгаажуулалт хийх тал дээр хамтран ажилласан. Санхүүжилт хугацаандаа олгогдвол гүйцэтгэгч талууд ажлаа түргэн хугацаанд чанартай гүйцэтгэх нөхцөл бүрдэж байна.</p> <p>Өмнөговь аймаг: Хөтөлбөрт тусгагдсан хот байгуулалт, дэд бүтэц, орон сууцны хангамж, үйлдвэржилтийг дэмжих зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд дээр дурдсан хөрөнгө оруулалтуудаар амжилттай сайн хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>

9	Төсөл Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт дундаж	Арга хэмж ээ тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зори лт5
		87,8%	22	91,6%	80%	85,7%	90%	90%
10	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт /ЗГ ХЭГ-	Нэгдсэн үнэлгээ%						

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ